

“ЭРХ МЭДЭЛЖҮҮЛЭХ” БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ



Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын

УДИРДАМЖ



Энэхүү товхимлыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрөлтэйгөөр Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” төслийн санхүүжилтээр 600 хувь хэвлэв.

СЗСҮТ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн гудамж, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв
20-р салбар, Ш,х: №364
Утас:352423
Цахим шуудан: info@nrc.gov.mn
Цахим хуудас: www.nrc.gov.mn

АИФО

Холбоо барих хаяг:
АИФО байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
Улаанбаатар 210648, Ш,х:75
Утас: 70153058

Дэлхийн зөн

Холбоо барих хаяг:
Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, 15-р хороо, (133-70), Энхтайвны өргөн чөлөө, 49-р барилга, Соманг плаза, 4-р давхар, Улаанбаатар 15160,
Шуудангийн хайрцаг 705
Вэб: <http://www.wvi.org/mongolia>

Орчуулсан: Д. Тулгамаа, АИФО байгууллагын суурин төлөөлөгч, нийгмийн ухааны магистр, докторант

Хянасан: Л.Энхбуянт, АИФО байгууллагын менежер, нийгмийн ухааны магистр, докторант

ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН СЭРГЭЭН ЗАСАХ ХАНДЛАГЫН УДИРДАМЖ **“ЭРХ МЭДЭЛЖҮҮЛЭХ”** **БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ**

Агуулга:

Өмнөх үг	03
Адвокаси /ухуулах нөлөөлөл, өмгөөлөл/ ба харилцаа.....	11
Хамт олныг хөдөлгөх.....	21
Улс төрийн оролцоо.....	31
Өөрөө өөртөө туслах бүлэг.....	39
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага	51

ДЭМБ-ын Номын сангийн каталоги

Хамт Олонд Түшиглэн Сэргээн Засах Хандлага: ХОТСЗ хандлагын Удирдамж

1.Сэргээн засалт. 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн. 3.Хамт олонд түшиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ. 4.Эрүүл мэндийн бодлого. 5.Хүний эрх. 6.Нийгмийн шударга ёс. 7.Хэрэглэгчийн оролцоо. 8.Удирдамж. I.Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. II.НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллага. III.Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага. IV. Хөгжлийн бэрхшээл, Хөгжлийн олон улсын консорциум

ISBN 978 92 4154805 2

(NLM ангилал: WB 320)

© Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага 2010

Бүх эрх хадгалагдсан. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хэвлэлийг WHO Press, World Health Organization, 20 Avenue, 1211 Geneva 27, Switzerland (tel: +41 22 791 3264; fax: +41 22 791 4857; e-mail: bookorder@who.int) -аас авч болно. ДЭМБ-ын хэвлэлийг орчуулах эсвэл дахин боловсруулж зарах эсвэл арилжааны бус байдлаар хэрэглэх алинд нь ч зөвшөөрөл авах ба ДЭМБ-ын Хэвлэлийн газарт дээр дурдсан хаягаар (fax: +41 22 791 4806; e-mail: permission@who.int) хандана.

Энэхүү хэвлэлийн дотоод агуулга нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын үзэл бодлыг илэрхийлэхгүй. Газрын зурган дээрх цэгэн зураас хилийг ойролцоогоор төлөөлсөн.

Үүнд дурдагдсан тухайн онцгойлсон компани эсвэл үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас зөвлөсөн эсвэл зөвшөөрсөн гэсэн үг биш.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага энэхүү хэвлэлд орж буй мэдээллийг баталгаажуулж бүх боломжит урьдчилан сэргийлэх аргуудыг авсан хэдий ч уг хэвлэлийг ямар нэгэн илэрхийлэл, зөвшөөрлийн баталгаагүйгээр тараасан болно. Орчуулгын хариуцлага болон уг материалыг ашиглах эрх нь уншигч танд буй. Үүнийг ашиглахад гарах ямар нэгэн хохирлыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага хариуцахгүй.

Хэвлэлийн дизайн, загварыг Inis Communication

www.iniscommunication.com

Мальтад хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

Эрх мэдэлжүүлэх нь Хамт олонд түшиглэн сэргээн засах (ХОТСЗ) матрицийн хамгийн сүүлийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ нь бүх салбарыг хамарсан сэдэв юм. Матрицийн эхний дөрвөн бүрэлдэхүүн хэсэг нь хөгжлийн гол салбарууд (эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, нийгмийн салбар)-тай холбоотой бол эрх мэдэлжүүлэх бүрэлдэхүүн хэсэг нь хөгжлийн бэрхшээлийг агуулж бүх салбарын гольдролд оруулж, хүн бүр эрхээ эдэлж, эрхэмсэг оршихуйг нь баталгаажуулахын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд, хамт олныг чадавхжуулахыг чухалд анхаарлаа хандуулсан хэсэг юм.

“Эрх мэдэлжүүлэх” гэдэг үг нь тухайн нөхцөл байдлаасаа шалтгаалаад өөр өөр утгыг агуулдаг, орон орны хэлээр тийм ч амархан орчуулагддаггүй (1). Энэ нэр томъёог энгийн үгээр тайлбарлавал: үг хэлэх, хэлж байгаа үгээ сонсох, өөрөө эрх мэдэлтэй байх, өөрөө шийдвэр гаргах, хянах эсвэл цаашдаа хянах боломжтой болох, чөлөөтэй байх, бие даасан байх, хэн нэгний эрхийг хамгаалах чадвартай байх, бусдад танигдах, бусдын нэгэн адил иргэн гэж хүндлэгдэх, ямар нэгэн зүйл хийхэд хувь нэмрээ оруулдаг хүн гэх мэт (1,2).

ХОТСЗ-ын ихэнх хөтөлбөрүүд нь хөгжлийн бэрхшээлтэй тухайн хүнээс ямар нэгэн зүйл асуулгүй сэргээн засалтыг үзүүлдэг эмнэлгийн загварт анхаарлаа хандуулдаг. Энэ нь олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эерэг өөрчлөлт үзүүлдэг хэдий ч энэ загвар нь үйлчилгээ хүлээн авагч, үзүүлэгч гэсэн хараат загвар юм. Хэсэг бүлэг хүн эсвэл хувь хүн өөрсдийнхөө нөхцөл байдлыг өөрчилж чадна, мөн түүнийгээ хийж эхэлнэ гэдгээ таньж эхэлсэн цагаас эрх мэдэлжүүлэх явц эхэлдэг. Энэ нь хүмүүс чадваржиж, ойлголттой болж өргөн хэмжээгээр оролцох, шийдвэр гаргах эрх мэдэлтэй болж, хяналт тавьж, өөрчлөлтийг хийх үйл ажиллагаа эхлүүлэх зэрэг үйл явдлууд эхлэх процесс юм (2).

ХОТСЗ-ын хандлагын төв нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд, хамт олон байдаг. Энэхүү Удирдамж нь ХОТСЗ-ын уламжлалт загвараас хамт олонд түшиглэсэн хамруулан хөгжүүлэх загвар луу шилжихийг дэмжиж байна. Ямар ч ХОТСЗ-ын хөтөлбөрийн эхлэх цэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бөгөөд тэдний гэр бүлийн гишүүд, хамт олныг эрх мэдэлжүүлэхэд чиглэх ёстой. Учир нь тэд зорилго, үр дүн, тогтвортой байдлын ололт амжилтыг авчрахад тэргүүлнэ.



Жишээ 1 Малау, Африк

Ил тод, дуу хоолойгоо гаргах, идэвхтэй байх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настнуудын Яамны (MPWDE) дэргэд байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Малаугийн зөвлөл (МАСОНА) нь Малау улсад ХОТСЗ-ын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байна. МАСОНА нь эрүүл мэнд, боловсрол, санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хүйс, хүүхдийн хөгжил ба хамт олны хөгжлийн асуудлуудыг хариуцдаг бусад яамдуудтайгаа болон Малауигийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын Холбоо (FEDOMA), Кристофел Блайнден Мишн (CBM), Олон улсын Хараа хамгаалах байгууллага болон Норвегийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмлэгүүдтэй хамтарч, түншилж ажилладаг юм.

ХОТСЗ-ын Удирдамж, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухайн НҮБ-ын Конвенци, мөн Африкийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Арван жил” зэрэг нь үндэсний ХОТСЗ-ын хөтөлбөрийг боловсруулах ерөнхий хүрээгээр хангасан. Малауигийн засгийн газар ХОТСЗ-ын хандлагыг өөрийн оронд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрэх давуу эрхтэй хандлага гэж хүлээж авсан. МАСОНА нь ХОТСЗ-ын матрицийн эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны бүрэлдэхүүн хэсгүүдийг шууд хариуцдаг, харин матрицийн нийгмийн болон эрх мэдэлжүүлэх бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэхэд FEDOMA болон бусад төрийн бус байгууллагууд, засгийн газрын яамдууд болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай ажиллаж байна.

МАСОНА, FEDOMA болон түншлэгчүүд дүүрэг, хороонд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх мэдэлжүүлэхэд тэдэнтэй шууд хамтран ажиллаж байна. Эрх мэдэлжүүлэх явц нь хамт олонд ойлголт өгөх хөтөлбөр, хамт олныг хөдөлгөөнд оруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг зохион байгуулалтанд оруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хороо байгуулах зэргээр эхэлнэ. Түүний дараа хорооны гишүүдийг ХОТСЗ-ын хандлагын ерөнхий ойлголтыг илүү өргөн утгаар өгөх, гольдролд оруулах, орон нутгийн засгийн газартайгаа зөвшилцөж чаддаг болгох, хөгжлийн бусад төсөл, хөтөлбөрүүдээс ашиг хүртэхийг нь хүртээмжтэй болгох зэргээр сургалтанд хамруулна. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын өмнө ил гарч, дуу хоолойгоо хүргэж, ярьж, идэвхтэй байснаар эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны боломжууд тэдэнд хүртээмжтэй болох боломжтой. Улмаар тэдний оролцоо, ижил тэгш боломжийг дэмжиж, өөрөө өөртөө итгэлтэй байх байдлыг сайжруулахыг дэмжинэ.

Норвегийн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмлэгийн хийсэн үнэлгээгээр МАСОНА нь ХОТСЗ-ын матрицийн таван бүрэлдэхүүний бүгд дээр нь ажиллаж байгаа хэдий ч “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх мэдэлжүүлэх, ялангуяа улс төрийн болон эдийн засгийн эрх мэдэлжүүлэх” хэсэг дээр анхаарлаа хандуулж байна гэжээ. Мөн уг үнэлгээгээр Малауигийн ХОТСЗ-ын хөтөлбөр олон яамд, төрийн бус байгууллагууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг нэг дор авчирснаараа хөтөлбөр үр дүнтэй, ашигтай байна гэж үзжээ.



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүдийг өөрсдөө шийдвэрээ гаргаж, өөрсдийнхөө хамт олныг сайжруулж, тэдний амьдралыг өөрчлөх хариуцлагыг тэдэнд өгөх.

ХОТСЗ-ын үүрэг

ХОТСЗ-ын үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүдийн амьдралд нь нөлөөлөх асуудалд өөрсдийг нь идэвхтэй оролцуулж, дэмжиж эрх мэдэлжүүлэх явцад хувь нэмрээ оруулахад оршино.

Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс авсан мэдээллийнхээ дагуу сонголт хийж, шийдвэрээ гаргаж чаддаг болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүл болон хамт олныхоо дунд идэвхтэй оролцогч, хувь нэмрээ оруулагч байна.
- Хамт олон дотор байгаа саад бэрхшээл арилж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чадвартай, чадалтай хүмүүс гэж хүлээн зөвшөөрдөг болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүд хөгжлийн үйл ажиллагаанаас ашиг хүртэж, хамт олон дотроо үйлчилгээгээ авч чаддаг болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд хамтдаа ирж, өөрсдийнхөө бүлэг эсвэл байгууллагыг байгуулж, тулгардаг нийтлэг асуудлынхаа төлөө ажиллана.

Гол ойлголтууд

Эрх мэдэлгүй байх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх нь гэр бүлдээ болон хамт олон дотроо эрх мэдэлгүй байдаг. Тэднийг гэр бүлийн гишүүд нь маш ихээр дэмждэг хэдий ч мөн дэндүү хамгаалж, тэдний өмнөөс гэр бүлийн гишүүд нь юмыг нь хийж, эсвэл хүмүүсийн дунд байдаг буруу ойлголтоос, мөн ялгаварлан гадуурхалтаас үүдэн хамт олон нь тэднийг гадуурхаж болно. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст маш бага боломж, сонголт байдаг, тэд харууслын бай болж, хохирогч болж, өөрчлөлтийг хийх хүн биш гэж үздэг. Сөрөг хандлага, дутуу үнэлснээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрх мэдэлгүй мэт сэтгэгдэл төрж, юу ч хийж чадахгүй эсвэл өөрийнхөө амьдралыг өөрөө өөрчилж чадахгүй, үнэ цэнэгүй, чадваргүй, өөрийгөө илэрхийлэх байдал сул, өөртөө итгэлгүй болдог. Эрх мэдэлгүй байхаас эрх мэдэлжүүлэх хайлт эхэлдэг.

Эрх мэдэлжүүлэх ба урамшуулах

Эрх мэдэлжүүлэх гэдэг нь цогц процесс юм. Энэ нь гэнэт бий болдоггүй эсвэл хэн нэгэнд юм өгдөггүй (2). Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг идэвхгүй хүлээн авагчаас идэвхтэй хувь нэмэр оруулагч болгож, оюун бодлыг нь өөрчлөхөөс өөрчлөлт эхэлнэ. Бодлын хувьд өөрчлөгдөнө гэдэг бол маш чухал, учир нь ингэснээр хамт олон дотор байгаа хандлагын, бүтэцийн мөн хөдөлгөөний саад бэрхшээлийг даван туулна. ХОТСЗ-ын хөтөлбөр нь ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл өгөх, чадавхийг бэхжүүлэх, шийдвэр гаргах, хяналт тавихад хүргэдэг оролцоог дэмжих зэрэг үйл ажиллагааг энэ нэр томъёон дор явуулж болно.

Ойлголт

Ойлголт нь хувь хүний өөрийнхөө тухай, амьдарч байгаа нийгмийнхээ тухай, өөрсдийнхөө нөхцөл байдлын тухай ойлголтын түвшин юм. Ойлголт нэмэгдүүлэх нь хүмүүст өөрчлөлт хийх боломжуудын талаар танихад нь тусалдаг (3). Гэр бүлийнхээ болон хамт олныхоо хөгжлийн бэрхшээлийн асуудал мөн хүний эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг саад бэрхшээлийг арилгахад тусалж, улмаар оролцоо болон шийдвэр гаргахад илүү эрх чөлөөтэй болно.

Мэдээлэл

Мэдээлэл бол эрх мэдэл бөгөөд ХОТСЗ-ын хөтөлбөрийн гол үйл ажиллагаануудын нэг нь мэдээлэл түгээх явдал юм. Хүмүүс ядуу байх тусам өөрсдийнхөө эрх/ эрхэмсэг оршихуйн талаар үндсэн мэдээлэл бага авдаг. Мэдээллийг түгээснээр хүмүүс боломжийнхоо давуу талыг олж авч, үйлчилгээнд хүрч, эрхээ эдэлж, үр дүнтэй зөвшилцөлд хүрч, үүргээ сайн биелүүлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь, мөн тэдний ойлгогдохуйц хэлбэрээр өгөхгүй бол тэд өөрчлөлтийг хийж, үр дүнтэй үйл ажиллагааг хийх боломжгүй (1).

Чадавх бэхжүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүлдээ болон хамт олон дотроо утга учиртай оролцож, хувь нэмрээ оруулахын тулд төрөл бүрийн чадвар, мэдлэг хэрэгтэй. Чадвар, мэдлэгтэй болгох нь эрх мэдэлжүүлэх процессын чухал хэсэг болох өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлдэг.

Бие биендээ туслах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх нь ганцаараа энэ бэрхшээлтэй учирсан гэж боддог, гэтэл тэд ижил төрлийн бэрхшээлтэй хүмүүстэй уулзахад тэдний бэрхшээл нь нийтлэг, түүнд нь нийтлэг шийдвэр байгаа гэдгийг олж мэддэг. Хамтдаа байснаар тэдний тусгаарлагдах нь багасч, бие биендээ туслах нь ихэсдэг. (Өөрөө өөртөө туслах бүлэг ба Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага хэсгийг үзнэ үү.)

Оролцоо

Хувь нэмрээ оруулснаар нийгэмд танигддаг. Энэ нь эрх мэдэлжүүлэх процессын нэг чухал хэсэг нь юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс маш олон түвшинд эерэг хувь нэмэр оруулж, оролцож чадна. Тухайлбал: гэртээ гэр бүлийнхээ хэн нэгнийг асрах, мал маллах, насосоор ус татах, хоол хийх, цэвэрлэх зэрэг ажлуудыг, харин хамт олон дотроо тэд саяхан хөгжлийн бэрхшээлтэй болсон нэгэндээ зөвлөгөө өгөх, бүлэг болон байгууллагынхаа гишүүдийн нэгэн адил оролцох зэрэг ажлуудыг хийж чадна.

Эвсэл, нэгдэл ба түншлэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо хязгаарлагдмал учир тэд хамруулах, хөгжүүлэх зорилго нэгтэй хүмүүстэй хамтарч эвсэл, нэгдэл болон түншлэл байгуулдаг. Өөр бусад бүлгүүд оролцож хамтарч үр дүнтэй үйл ажиллагаа явуулж чадвал тэд хамрагдаж, хамт олон үйл ажлынхаа эзэн нь болдог.



Жишээ 2 Монгол

Сайн жишээ: Чулуундолгорын амьдрал

Түүний бага нас бусад хүүхдийн нэгэн адил байв. УБ хотоос 460 орчим км-ийн зайтай хөдөө суманд амьдардаг тэрээр дунд сургуулийн сурагч байхдаа гэнэтийн осолд орж, нугасны хүнд гэмтэл авсан байна. Яаралтай хагалгаанд орох шаардлагатай байсан тул түүний аав ээж Улаанбаатар хотод авчирч 6 цаг үргэлжилсэн хүнд хагалгаанд оруулжээ. Хагалгааны дараа бие нь тэнхэрч хүч чадалтай болох хүртэл нэг жилийн хугацаа өнгөрсөний эцэст тэргэнцэр дээр бага зэрэг суудаг болсон хэдий ч өдөр тутмын үйл ажиллагаагаа бие даан хийж чадахгүй, бусдаас хараат, сул дорой хэвээр байсаар л байв.

Тэр үед сумын “Тэгш дүүрэн” хорооны зохицуулагч эмч түүнд “Нуруу нугасны гэмтэлтэй хүний гарын авлага” номыг өгсөн нь маш их тус хүргэжээ. Тэрээр номын заавар болгоны дагуу өдөрт 4-6 цагийн дасгал хөдөлгөөнийг хийдэг байв. Мөн түүний аав гарын авлагын дагуу хашаандаа тохиромжтой ариун цэврийн өрөөг хийж өгсөн нь түүний бусдаас хараат бус байх, бие даах чадварыг нэмэгдүүлэхэд сайнаар нөлөө үзүүлжээ.

Хэсэг хугацааны дараа тэр сургуулиа төгсөхөөр шийдэж, сурч байсан сургуулийнхаа багш нартайгаа уулзан даалгавар авч гэрээрээ хичээллэн төгсөх шалгалтаа амжилттай өгч, улмаар дээд сургуульд суралцахаар болж, түүний гэр бүл хотод шилжин ирэв. Бизнесийн эдийн засагч удирдлагын менежер мэргэжлээр сургуулиа амжилттай дүүргээд тухайн үед хамгийн их өргөн сүлжээтэй байсан Хаан банкинд ажилд орох хүсэлт тавьсан боловч түүний саналыг хүлээн авсангүй. Учир нь тус байгууллагад тэргэнцэртэй хүн орох зориулалтын зам, ариун цэврийн өрөө байхгүй байв. Энэ байдлаар тэр олон газарт хандаж ажилд орохыг хүссэн боловч алинаас нь ч нааштай хариу авч чадаагүй аж.

Энэ үеэс нийгэм тэгш бус байна гэдгийг ойлгож ... яагаад? гэж бодож эхэлснээ хожим тэр дурсан ярьдаг.

Тэр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагуудаар очиж, өөртэйгөө адил үзэл бодолтой олон ХБХ-тэй

танилцан 2005 онд Тэргэнцэртэй иргэдийн холбоо ТББ-ыг үүсгэн байгуулахад санал нэгдэн идэвхийлэн оролцов. 2006 онд АИФО байгууллага, НҮБ-ын Нийгэм эдийн засгийн хэлтэстэй хамтран хэрэгжүүлсэн “ХБИБ-уудын чадавхийг бэхжүүлэх” төсөлд хамрагдан Хүний эрхийн 9 сургагч багш бэлдсэний нэг нь болов. 2008 онд бусад ХБИБ-уудтайгаа сүлжээ болон ажиллаж, хүний эрхийн үндэсний комисстой хамтран УИХ-аар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг соёрхон батлуулах ажилд гар бие оролцон, зорилгодоо хүрсэн билээ. 2010-2014 онд конвенцийн хэрэгжилтийг шаардан сануулсан нөлөөллийн ажлуудыг өргөн хүрээнд зохион байгуулж байжээ. 2015 онд Зам тээврийн сайдтай уулзаж, нийтийн тээвэр, галт тэрэг, орон нутгийн тээвэр, онгоцны буудлыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгоход нөлөөллийн ажил хийсний үр дүнд Монгол улсад анх удаа хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан нэг вагонтой болсон. Одоо энэхүү вагон нь Улаанбаатар-Сүхбаатар, Улаанбаатар-Сайншандын чиглэлд явж, хүмүүст үйлчилж байна. 2015 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаар сүүдэр илтгэл бичихэд манлайлан оролцож, мөн түүнийгээ хамгаалж, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооны хуралд оролцохоор Женев хотноо бусад ХБИБ-уудын төлөөлөлүүдтэйгээ хамтран оролцсон нь түүний чадавхийг нэмэгдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. Одоо Чулуундолгор бодлогын хэмжээний бүх үйл ажиллагаанд тэргэнцэртэй хүмүүсээ төлөөлөн оролцож байгаа бөгөөд саяхан байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Үндэсний Зөвлөлийн гишүүн болсон. Энэхүү Зөвлөл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд зориулан Ерөнхий сайдаар ахлуулж байгуулагдсан билээ. ХОТСЗ “Тэгш Дүүрэн” хөтөлбөр, АИФО байгууллагатай маш идэвхтэй хамтран ажилладаг тэрээр “....Гэхдээ би АИФО байгууллагатай бодсоноосоо аль эрт холбогдсоноо сүүлд мэдсэн юм....Ямар дасгал хөдөлгөөн хийх тухай гарын авлагыг ашиглаж эхэлсэн тэр үе минь миний ХОТСЗ “Тэгш Дүүрэн” хөтөлбөр”, АИФО байгууллагатай холбогдож эхэлсэн анхны цаг үе байсан” гэж Италийн Милан хотноо зохион байгуулагдсан ЕХРО дээрх нэгэн тусгай үйл ажиллагаан дээр дурсан, сэтгэлээ хуваалцсан юм. Түүний амьдралын жишээ ХОТСЗ “Тэгш Дүүрэн” хөтөлбөр”-өөр дамжуулж амьдралаа өөрчилсөн олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн жишээний нэг юм.

Энэ бүрэлдэхүүн хэсгийн элементүүд

Адвокаси/ ухуулах нөлөөллөх, өмгөөлөл/ ба харилцаа

Энэ элемент нь өөрөө өөрийгөө өмгөөлөх (адвокаси)-д чухал шаардлагатай илгээх үгийг хүргэх, хүлээн авдаг аргууд буюу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө ярих, харилцах гэсэн утгатай. Энэ хоёр утга нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх мэдэлжүүлэхэд хэрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэр бүлийн гишүүд болон хамт олонтой нь холбодог, хүмүүст сонголтоо хийхэд нь хүч чадал өгдөг, үзэл бодлоо илэрхийлэх, өөртөө итгэлтэй болгодог, шийдвэр гаргуулдаг. ХОТСЗ-ын хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусад хүмүүстэй харилцах чадварыг нь сайжруулж, мөн тэднийг өөрөө өөрийгөө өмгөөлөх хамгаалах чадвар олгоход чухал үүрэг гүйцэтгэнэ.

Хамт олныг хөдөлгөх

Хамт олны оролцоо нь ХОТСЗ-ын хөтөлбөрийг амжилттай болгоход чухал юм. Хамт олныг хөдөлгөөнд оруулах нь тэдний гишүүдийг өөрчлөх, үйл ажиллагаа зохион байгуулахад эрх мэдэлжүүлэх зорилготой стратеги юм. Энэ стратегийг ихэнхдээ хөгжил буурай орнуудад хамт олны хөгжлийн асуудлуудад хандахад, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүдийн хэрэгцээнд тулгуурлаж, хамт олныг эрх мэдэлтэй байдлыг баталгаажуулахын тулд ХОТСЗ-ын хөтөлбөрүүдэд ашиглаж болно.

Өөрөө өөртөө туслах бүлэг

Өөртөө тохиолдсон нийтлэг бэрхшээлийг даван туулж, үйл ажиллагаануудыг хамтдаа хийх албан бүлгийг өөрөө өөртөө туслах бүлэг гэнэ. ХОТСЗ-ын хөтөлбөрүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг өөрөө өөртөө туслах бүлэг байгуулж, нэгдэж, оролцохыг дэмжиж, хувь хүнээс гадна үйл ажиллагаанд нь анхаарлаа хандуулах хэрэгтэй. Өөрөө өөртөө туслах бүлэгт оролцсоноор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамт олон дотроо орж, бие биендээ туслаж, нөөц бололцоогоо хуваалцаж, хамтарч шийдвэрээ гаргаж, өөртөө итгэх итгэлтэй болох нь сайжирна. ХОТСЗ-ын хөтөлбөр өөрөө өөртөө туслах бүлгээр дамжуулж эрх мэдэлжүүлэх явцыг чиглүүлэх, өмнөө тавьсан зорилгуудынхаа заримыг нь биелүүлэх боломжтой. Энэ элемент нь ХОТСЗ-ын хөтөлбөрүүд хэрхэн өөрөө өөртөө туслах бүлэг байгуулж, чиглүүлж, дэмжих талаар анхаарлаа хандуулна.

Улс төрийн оролцоо

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг улс төрд оролцохыг дэмжих нь эрх мэдэлжүүлэх явцын чухал хандлага юм. Шийдвэр гаргах нь улс төрийн хувьд гол цөм нь байдаг. Тиймээс улс төрийн оролцоо нь асуудалд өртсөн хүмүүсийг шийдвэрийн гол цөмд оруулж, өөрчлөлтөнд нөлөө үзүүлнэ. Хүмүүс улс төрд оролцох олон арга байдаг, тухайлбал албан (үндэсний болон орон нутгийн намын улс төр) ба албан бус (найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ улс төрийн талаар ярилцах). Энэ элемент нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд шийдвэр гаргахад нөлөө үзүүлэх, тэгш эрхээ мөн боломжоо эдлэхийг нь баталгаажуулах практик аргуудыг нээн илрүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага

Дэлхийн өнцөг булан бүрт ажилчид нэгдэн өөрийн ажлынхаа ашиг сонирхлыг хамгаалж, дэмжихийн тулд хамтран ажилладагийн нэгэн адил хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамтарч, өөрсдийнхөө ашиг сонирхлыг хамгаалж, дэмжихийн тулд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага”-ыг байгуулдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага бүс, үндэсний болон олон улсын түвшинд байдаг ба ихэнхдээ албан ёсны бүтэцтэй байдаг бөгөөд тэд адвокати (өөрөө өөрийгөө өмгөөлөх), болон өөрсдийнхөө төлөөллийг оруулсан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг. Ийм байгууллагуудыг дэмжих нь

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх мэдэлжүүлэх явцыг дэмжих нэг арга нь болдог. ХОТСЗ-ын хөтөлбөр хэрэгжиж байгаа газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага хөтөлбөртэй зэрэгцэн оршдог ба тэд хамтарч ажиллах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага байхгүй бол ХОТСЗ-ын хөтөлбөрөөс үүнийг хамт олны түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага байгуулахыг нь дэмжих хэрэгтэй. Энэ элемент нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэрхэн байгууллагаа үр дүнтэй явуулахыг хамарна.



Адвокаси /ухуулга, нөлөөлөл, өмгөөлөл/ ба харилцаа

Танилцуулга

ХОТСЗ-ын хандлагын удирдамжинд адвокати-г санал болгосон үйл ажиллагаа гэж өмнө нь дурдсан билээ. Адвокаси-г өөр өөр аргаар, өөр өөр хүмүүсээр хийлгэж болно. Тухайлбал өөрөө өөртөө туслах бүлэг, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд өөрчлөлт хийхийн тулд шийдвэр гаргагчдад нөлөө үзүүлж, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бодлого, хөтөлбөрийг хамруулсан байхыг баталгаажуулж адвокати/ухуулга, нөлөөлөл, өмгөөлөл/ хийж болох юм. Энэ элементээр өөрөө өөрийгөө өмгөөлөх буюу хувь хүмүүс өөрсдийнхөө төлөө дуугарч эхлэхэд анхаарлаа хандуулна.

Өөрийгөө өмгөөлөх, адвокати амжилттай болох нь харилцах, илгээх үг (мессеж)-ийн чухал эсэхээс шалтгаална. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх нь харилцахдаа саад бэрхшээлтэй байдаг тул ихэнхдээ тэдний дуу хоолой сонсогдохгүй, тэд өөрсдийнхөө амьдралд нөлөөлөх асуудал, бодлого, үйлчилгээний талаарх шийдвэрт нөлөөлөхөд маш бага боломжтой байдаг (4). Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенци нь хөгжлийн бэрхшээлтэй эдгээр хүмүүст харилцааны асуудал маш чухлыг онцолсон байдаг. 9-р зүйл дээр "...мэдээлэл, харилцаа, холбооны технологи болон систем....бүхий мэдээлэл, харилцаа..."-г хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил тэгш эрхтэй хүртэх явдлыг Оролцогч Улсууд баталгаажуулна. Мөн 21-р зүйлээр "...өөрсдийн сонгосон бүх төрлийн харилцааны хэрэгслүүдээр дамжуулан тэгш эрхийн үндсэн дээр санаа бодол, мэдээллээ чөлөөтэй хайх, хүлээн авчүзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх" эрхийг баталгаажуулсан (5).

Өөрөө өөрийгөө өмгөөлөх, мөн үр дүнтэй харилцаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх мэдэлтэй болох явцын чухал хэсэг нь юм. Энэ элемент нь ХОТСЗ-ын хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэх үндсэн үйл ажиллагаануудыг санал болгож тэдгээрийн чухал зүйлүүдийг онцлох болно.



Бүтээлч амьдрал руу тэмүүлсэн Ханзагийн аялал

Ханза охин Энэтхэгийн Гужарат мужийн Данки гэдэг нэгэн бөглүү тосгонд хөдөөний гэр бүлд төржээ. Түүний гэр бүл олсон орлогоороо өдөр тутмынхаа амьдралыг болгодог хөдөлмөрчин гэр бүл юм. Сонсголгүй, сул хараатай, мөн оюун хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй Ханзаг тосгоныхон “Дээд эзний хараал” гэж нэрлэжээ. Хүмүүс тэднийхээс зугатаж, хэрэв ойрхон байвал муу аз авчирна гэдэг байлаа. Ханзагийн гэр бүл өдөрт олсон орлогоороо хоол хүнсээ авдаг байсан учир энэ буруу ойлголт, ялгаварлан гадуурхалт нь гэр бүлийг хүнд дарамтанд оруулж байв.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан Сенс олон улсын байгууллагын шугамаар сургалтанд сууж ирснээр Ханзагийн болон түүний гэр бүлийн амьдралд өөрчлөлт гарч эхэлсэн. ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан Ханзагийн гэрт тогтмол очиж эхэлснээр Ханзаг өөрийн орчин тойрноо тоглоом болон бусад ажлуудаар дамжуулж нээн илрүүлэхэд туслаж эхэллээ. Цаг хугацаа өнгөрч Ханзад дэвшил гарч хариу үйлдэл хийж эхэллээ. Тэр дохионы хэлээр харилцаж, вандуйг тоолж, арифметикийн энгийн үйлдлүүдийг хийж сурсан. Мөн ээждээ гэрийнх нь ажилд тусалж эхлэв. Сэгсгэр, арзайсан, даяанчийн байдалтай байсан Ханза сайхан хувцасласан, өөртөө итгэлтэй өсвөр насны охин болов.

Тосгоныхон хандлагаа өөрчлөхөд бага зэрэг цаг хугацаа орсон. Гэхдээ аажмаар өөрчлөгдөж эхэлсэн. Фермерүүд Ханзагийн эцэг, эхийг ажилд авч, мөн Ханзагийн авьяас, чадварыг нь анзаарч эхлэв. Одоо Ханза хөдөө аж ахуйн ажилчин болж гэр бүлийнхээ орлогод хувь нэмрээ оруулж байна. Тэдний гэр бүлийг нийгмийн болон хамт олны ажилд урин оролцуулж, Ханза өөрийнхөө насны хүүхдүүдээр бүлэг байгуулсан юм.



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийнхөө тухай ярьж чадна.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөрөө өөрийгөө өмгөөлөх болон харилцах чадвараа хөгжүүлэхэд туслах, тэдний хүрээлэн буй орчин тойрон нь тохирох боломжийг олгож байгаа эсэхийг бататгах, шийдвэр гаргахад нь тэдэнд туслах мөн өөрсдийнхөө хэрэгцээ болон хүсэл эрмэлзлийг үр дүнтэй илэрхийлэхийг нь дэмжих.

Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн мэдээлэл, харилцааны нөөц бололцоонд хүрэх хүртээмж сайжирна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст харилцахад тулгардаг саад бэрхшээл багасгаж, арилна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд өөрсдийнхөө хүндэлж байдаг хамт олон дотроо өөрсдийгөө төлөөлдөг болно.
- ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан нь үр дүнтэй харилцагч байх бөгөөд харилцааны бэрхшээлтэй болон бүх гол хүмүүстэй мэдээллээ солилцдог болно.

Гол ойлголтууд

Өөрөө өөрийгөө өмгөөлөх

Өөрөө өөрийгөө өмгөөлөх гэж юу вэ?

Ихэнх хүмүүс өөрсдийнхөө хувийн хэрэгцээг гүйцэлдүүлэхийн тулд өдөр тутам өөрөө өөрийгөө өмгөөлж байдаг. Өөрөө өөрийгөө өмгөөлнө гэдэг нь хүмүүс өөрсдийнхөө дуу хоолойг гаргах гэсэн үг. Өөрөөр хэлбэл энэ нь эрх болон хариуцлагаа мэдэж, эрхийнхээ төлөө ярьж, өөрсдийн амьдралтай холбоотой сонголт хийж, шийдвэр гаргах чадвартай байна гэсэн үг.

Яагаад чухал вэ?

Өөрөө өөрийгөө өмгөөлөх нь эрх мэдэлжүүлэх үйл явцын чухал хэсэг нь юм. Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амьдралынхаа ихэнх хугацаанд тэдний хэлснийг сонсдоггүй, мөн юу хийхээ хэлүүлэлгүйгээр өнгөрүүлдэг. Шийдвэрийг ихэнхдээ өөр бусад хүмүүс тэдний өмнөөс гаргадаг. Өөрөө өөрийгөө өмгөөлөх чадварыг эзэмшсэнээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ хамгаалах, өөрийнхөө амьдралд хяналт тавих, өөртөө тохирсон хамгийн сайн шийдвэрийг гаргах зэрэгт суралцана. Өөрөө өөрийгөө өмгөөлөх гэдэг нь хамгийн энгийнээр тайлбарлалбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс юу идэх, өмсөхөө сонгох, эсвэл арай өөр түвшинд тэдэнд чухал ямар нэгэн сэдвийн талаар, тухайлбал хэрэглэж байгаа үйлчилгээндээ тайлбар өгөх, зэрэг асуудлуудаар нийтэд ярихыг хэлнэ.

Үр дүнтэй өөрөө өөрийгөө өмгөөлөх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг боловсруулж байх үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд чухал үүрэг гүйцэтгэсэн. 2006 оны 1-р сард Зөвшилцлийн зургаа дахь уулзалтын үеэр Бангладеш, Хятад, Английн хүүхдүүд Нью-Йорк хотод очиж, тэдний эрхийг хамгаалахад яагаад онцгойлсон арга хэмжээг Конвенцид оруулж өгөх хэрэгтэй байгаа талаар ярилцацгаасан. Тэд хүчирхийлэл, доромжлолыг бий болгодог институтуудыг хаахын чухлыг, мөн мэдээлэл, үйлчилгээг хүртээмжтэй байлгахыг баталгаажуулахыг онцолсон зүйлээ бичгээр үйлдэж, олон хүнд хүргэсэн. 2007 оны 3-р сард Конвенцид гарын үсэг зурах ёслолын ажиллагаан дээр Никарагуа, Арменаас хоёр залуу (өмгөөлөгчид) ирж энэхүү шинэ Конвенцийг хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдалд онцгой анхаарал тавихыг төлөөлөгчдөд сануулсан. Эдгээр хоёр залуугийн оролцоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөрсдийнхөө эрхийг хамгаалахад үр дүнтэй өмгөөлөгчид болж, тэд нарт хамаатай шийдвэрт хамтарч оролцож чадаж байгаагаа баталсан юм. (6,7,8,9).

Ямар дэмжлэг шаардлагатай вэ?

Ихэнх тохиолдолд хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар буруу ойлголттой байж, тэднийг ялгаварлан гадуурхдаг. Энэ нь тэднийг үзэл бодол, хүсэл, хэрэгцээгээ илэрхийлэхэд хүндрэлтэй байдаг байж болох юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнхэд нь өөрөө өөрийгөө өмгөөлөх чадварыг сурахад дэмжлэг хэрэгтэй байдаг (Санал болгож буй үйл ажиллагаануудыг үзнэ үү). Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд өөрөө өөрийгөө өмгөөлөх нь хамгийн эрхэм зорилго хэдий ч зарим тохиолдолд тэдэнд өмгөөлөгчийн дэмжлэг хэрэгтэй эсвэл тэд ийм дэмжлэг хүсдэг. Тэрхүү өмгөөлөгч нь гэр бүлийн гишүүд, найз нөхөд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагын гишүүн, хамт олны сайн дурын өмгөөлөгч, эсвэл ХОТСЗ-ын хөтөлбөрийн гишүүн байж болно. Өмгөөлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэдээлэл олоход, уулзалтын цаг авч өгөхөд, чухал зүйлийн талаар захиа бичиж өгөх, тэдний хүнд нөхцөл байдлын талаар тэдний өмнөөс ярих зэргээр туслаж болно.

Харилцаа

Харилцаа гэж юу вэ?

Харилцаа гэдэг нь нэг хүнээс нөгөө хүнд мэдээлэл, илгээх үг (мессеж) хүргэх арга хэрэгсэл, мөн хувь хүмүүс болон хамт олны хооронд бий болсон нийгмийн харилцааны хэрэгсэл юм. Үр дүнтэй харилцааны гурван бүрэлдэхүүн хэсэг бий: хэрэглэгдэхүүн, шалтгаан, боломж

- Хэрэглэгдэхүүн: мессежийг хэрхэн илгээх тухай. Аман болон бичгээр, дохионы хэлээр, мөн харилцааны туслах хэрэгслээр илгээж болно. Хүмүүс өөрсдийнх нь хэрэгцээнд бүрэн нийцсэн харилцааны хэрэглэгдэхүүн ашиглахыг шаарддаг (Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг: Туслах хэрэгсэл хэсгийг үзнэ үү)
- Шалтгаан: яагаад харилцах хэрэгтэй талаар. Олон шалтгаан байдаг: практик хэрэгцээгээ илэрхийлэх, тухайлбал юм уухыг хүсэх, үзэл, бодол, мэдрэмжээ илэрхийлэх, хэн нэгний нэрийг нь асуух, найз нөхөд болох эсвэл шог хошин яриа ярих гэх мэт.

- **Боломж:** бусад хүмүүстэй харилцахад хүмүүст байнгын боломжууд хэрэгтэй байдаг. Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст харилцах боломж байдаггүй, тухайлбал гэрт хүн ирэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ ихэнхдээ нуудаг, цус харвалтын дараа ярьж чадахгүй байгаа хүнийг гэр бүлийн шийдвэр гаргахад оролцуулдаггүй, сонсголгүй хүмүүст дохионы хэлний орчуулга байгаагүйгээс зөвлөлийн уулзалтанд оролцож чаддаггүй. Хязгаарлагдмал боломжууд харилцаа болон бусад чадваруудыг сурах, хөгжүүлэхэд саад болж болно.

Дуу хойлооноос өөрөөр хүмүүс харилцаж чадна

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд өөрөө өөрийгөө өмгөөлөх ойлголт нь өөрсдийнхөө дуу хоолойг гаргах талаар ярьж байгаа хэдий ч энэ нь яг ч дуу хоолой гэдэг үг шигээ байх албагүй. Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ярьж чадахгүй хэдий ч бусадтай амархан харилцаж чаддаг. Хөдөлгөөний, сонсголын, харааны болон оюун ухааны бэрхшээлүүд нь хүмүүсийн харилцах аргад нөлөөлдөг хэдий ч харилцах аргыг хөнгөвчилснөөр бүгд ойлгох боломжтой болно. Гэхдээ хамгийн гол нь хэн нэгэн хүн ярьж чадахгүй байгаа нь харилцах чадваргүй гэсэн үг биш. Хүн бүр харилцах чадвартай байдаг. Харилцаа гэдэг нь зөвхөн хэл яриа гэсэн үг биш.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн дуртай, дургүй байгаагаа, мөн хүсэл, хэрэгцээгээ үгнээс өөр хэлбэрээр илэрхийлдэг. Харилцаанд дараах хэрэглэгдэхүүнүүд хамрагдана. Үүнд: "...текст, Брайл, тактилан харилцаа, том фонтоор хэвлэх, бичгэн, аудио, ойлгомжтой хэл, хүн унших гэх мэтийн хүртээмжтэй мультимедиа, нэмэлт буюу альтернатив загвар, хүртээмжтэй мэдээлэл болон харилцаа холбооны технологи гэх мэтийн харилцааны формат ба хэрэглэгдэхүүн" (5) (Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг: Туслах хэрэгсэл хэсгийг үзнэ үү).

Жишээ 5 Вьетнам

Транг харилцаж сурав.

Транг 14 настай, алслагдсан тосгонд гэр бүлтэйгээ хамтарч амьдардаг. Транг тархины саатай бөгөөд харилцааны бэрхшээлтэй. Түүний гэр бүлийнхэн, найз нөхөд нь түүний яриаг ойлгодоггүй, түүний хөдөлгөөн нь зохицуулагдаагүй учир дохионы хэл хэрэглэж чаддаггүй. Ихэнх хүмүүс Трангийг харилцааны чадвар нь хязгаарлагдмал учраас оюун ухааны хомсдолтой гэж боддог. Трангийн авга эгч нь ХОТСЗ-ын хөтөлбөрт хандаж, тусламж хүссэн. ХОТСЗ-ын ажилтан Трангийн амьдралд их тааралддаг хамгийн чухал зүйлүүдийг агуулсан зураг бүхий мэдээллийн самбар хийхэд тусалсан. Одоо Транг тэр мэдээллийн самбарыг ашиглаж, нүдээрээ хэрэгцээгээ зааж, мэдээлэл солилцож, гэр бүлийнхэнтэйгээ болон найзуудтайгаа ярилцаж байна. ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан гэр бүлийнхнийг нь Трангийг уншиж сургаж эхлэхийг зоригжуулсан.



Харилцааны саад бэрхшээл

Өөрөө өөрийгөө өмгөөлөх гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сонсох гэсэн үг. Харилцахад тулгарч байгаа саад бэрхшээлийг олоход нь чухал. Дөрвөн үндсэн саад бэрхшээл байдаг: бие бялдрын саад бэрхшээл (хол зай, эсвэл орчны замбараагүй байдал гэх мэт), утгын саад бэрхшээл (хэцүү үг эсвэл тусгай үг хэрэглэх), хандлагын саад бэрхшээл (бардамнал болон тэвчээргүй байдлаас болж өөрийгөө илэрхийлэхэд бэрхшээлтэй байдаг хүнтэй харилцахаас зайлсхийх), мэдээллийг байршуулах (тохиромжгүй цаг хугацаанд, эсвэл хэтэрхий их мэдээлэл). Харилцааг үр дүнтэй болгохын тулд байгаа саад бэрхшээлийг олж, түүнийг даван туулах арга хэмжээг авах нь чухал.



Санал болгож буй үйл ажиллагаанууд

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх мэдэлжүүлэх үр дүнтэй харилцааг хөгжүүлэх, өөрөө өөрийгөө өмгөөлөхөд нь туслахын тулд ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан зөвхөн хувь хүнд, орчин тойронд нь хандах биш, тэдний харилцах чадварт нь хандах ёстой.

Харилцааны үндсэн үнэлгээг хий

Харилцацгаая: Харилцааны бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах хүмүүст зориулсан гарын авлага(10) гэх мэтийн гарын авлага, материалууд нь харилцааны үнэлгээний талаарх цогц мэдээлэл өгнө. Харилцааны чанарыг үнэлэхэд зарим үндсэн зүйлүүдийг анхаарч байх ёстой. Үүнд:

- Харилцааны ямар аргыг одоо хэрэглэж байна вэ?
- Түүнийг хэр сайн ашиглаж байна вэ? (хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй хүмүүсийн аль алиных нь чадварыг анхаарч үзнэ үү)
- Харилцааны тогтолцоо нь хүн бүрт ойлгомжтой байна уу?
- Хөгжлийн бэрхшээлгүй хүн хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээг үнэн голоосоо ойлгодог уу?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн хэнтэй голцуу харилцдаг вэ?
- Яагаад хөгжлийн бэрхшээлтэй хүн харилцдаг вэ? Нэгдэх гэж, практик хэрэгцээгээ илэрхийлэх гэж, эсвэл мэдрэмжээ илэрхийлэх гэж харилцдаг уу?
- Хүмүүст харилцахад ямар төрлийн боломжууд байдаг вэ? Түүнтэй ярих олон хүмүүс байдаг уу эсвэл тэр ганцаараа байдаг уу?
- Сайн харилцаанд тулгарах саад бэрхшээл байдаг уу?
- Статус, эрх мэдэл, үүрэг нь харилцаанд нөлөөлдөг үү? Тухайлбал: хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүн эрэгтэй хүний өмнө ярьдаг уу? Гэр бүлийнхэн нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнээ харилцахад нь дэмжлэг үзүүлдэг үү?

Харилцааны чадвар эзэмшихэд нь дэмжлэг үзүүл

Харилцааны чадварыг нь хөгжүүлэхийн тулд ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүдтэй нягт ойр хамтран ажиллах хэрэгтэй. Тусламж дэмжлэгийг хувь хүний нөхцөл байдал болон хэрэгцээн дээр тулгуурлаж ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан эсвэл өөр хэн нэгэн хүн үзүүлж болно. “Харилцацгаая” гэх мэтийн гарын авлагууд нь олон ашигтай санаануудыг өгнө. Харилцааны бэрхшээлтэй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илрүүлэхдээ ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан дараах зүйлүүдэд анхаарал тавина. Үүнд:

- Хэл засал гэх мэт нарийн мэргэжлийн үйлчилгээнд зуучилж өгөх;
- Зарим нэгэн хүмүүс ярьж чадах боломжгүй гэдгийг гэр бүлийн гишүүдэд ойлгуулж, харилцааны бусад хэлбэрүүд: тухайлбал: дохионы хэл, харилцах самбарын талаар мэдээлэл өгөх;
- Шаардлагатай бол харилцааны туслах хэрэгсэл хүртээмжтэй байгаа эсэхийг баталгаажуулах; мөн гэр бүлийн гишүүдэд нь туслах хэрэгслүүдийг хэрхэн хийх талаар үзүүлэх. (Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг: Туслах хэрэгсэл-ийг үзнэ үү.)
- Сонсголын аппарат хэрэгтэй хүмүүст түүнийг ашиглах, арчлах, тохируулах, боломжтой байгаа эсэх талаар холбогдох мэдээллийг өгөх;
- Дохионы хэл зааж өгөх эсвэл дохионы хэлний зааврыг хаанаас авах талаар мэдээлэл өгөх;
- Харилцааны бэрхшээлтэй хүмүүсийг өдөр тутмын үйл ажиллагаа (зах явах, хоол хийх, цэвэрлэх, ус татах гэх мэт)-нд хамруулж, хүмүүсийн хэрэглэдэг хамгийн энгийн үг, хэллэг, дохиог зааж өгөх;
- Хүмүүсийн хооронд нийгмийн харилцаа үүсгэдэг, боломжуудыг олгодог бүлэг/клубуудад, тухайлбал: сонсголгүй иргэдийн клуб, цус харвалттай хүмүүсийн клуб, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спортын клубуудтэй холбох.

Жишээ 6

Стефани шинэ ертөнцийг сонсож байна

Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд гэр бүлийнхэнтэйгээ, найз нөхөдтэйгээ мөн багш нартайгаа харилцахад нь туслахын тулд сонсголын аппарат хэрэглэх шаардлагатай байж болох юм. ХОТСЗ-ын хөтөлбөр туслах хэрэгсэлтэй болоход нь тусалж, түүнийгээ хэрхэн хэрэглэх, засварлах талаар зааварчилгааг өгч болно. Мөн ХОТСЗ-ын хөтөлбөр бага үнэтэй батерей байгаа эсэхийг олж, боломжтой бол дохионы хэл ашиглахыг дэмжиж болно.

Стефанийн сонсголын бэрхшээлийг олон жилийн туршид илрүүлээгүй байжээ. Тэр охин маш хол амьдардаг бөгөөд зөвхөн ээжтэйгээ л харилцдаг байв. Орон нутгийн ХОТСЗ-ын хөтөлбөрийн сайн дурын идэвхтэн эмч түүний сонсгол алдагдалт нь чихний архаг халдвараас болсныг олж илрүүлжээ. Түүнд халдварын эсрэг эмчилгээ хийж, сонсголын аппарат тааруулж өгөв. Стефани бага сургуульд явж, түүнд шинэ мэдлэгийн хүрээг нээж өгөв. Одоо тэр бусдаас тусгаарлагдаагүй, өдөр тутам найзуудтайгаа харилцаж байна.

Харилцааны саад бэрхшээлүүдийг ол

ХОТСЗ-ын хөтөлбөр орчинд буй харилцааны саад бэрхшээлүүдийг дараах аргуудаар арилгах, эсвэл багасгахад туслаж чадна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, насанд хүрсэн хүмүүст харилцах боломжийг дээд хэмжээгээр олгохын тулд гэрт нь эерэг хандлага бий болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцах болон тэднийг юу хэлж байгааг сонирхож байгаа гол хүмүүсийг олох;
- Хүмүүсийн эрхэм болгож буй харилцааны хэлбэрийн талаар бусадтай мэдээлэл солилцох; Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие дааж харилцаж чадах хэлбэрийг боловсруулах нь чухал, өөрөөр хэлбэл ХОТСЗ-ын хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцах хамгийн сайн аргын талаар бусдад хэлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “миний харилцааны хуудас”-ыг боловсруулж болох юм.
- Гэр бүл, хамт олонд харилцааны стратегийг зааж өгөх нь харилцахад илүү цаг зарцуулах, энгийн хэл, дохио, тэмдэг, зураг, эсвэл Брайл ашиглах гэх мэтээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ашигтай байж болох юм;
- Хамгийн дээд хэмжээгээр харилцахад орчинг хэрхэн өөрчлөх талаар санал тавих, тухайлбал чимээгүй орчинд сонсголын бэрхшээлтэй хүмүүстэй ярих, уруулын хайрцаг харж уншдаг хүнд зориулж гэрлийг тохируулах гэх мэт.
- Дохионы хэлний орчуулагчийг их хэмжээгээр бэлтгэх. Үүнийг хийхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагатай түншилж ажиллах хэрэгтэй;
- Харилцааны бэрхшээлтэй хүмүүст тулгардаг бэрхшээлийн талаар хамт олны ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор олон нийтийн уулзалт эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай хамтран бүх үйл ажиллагаанд, тухайлбал сургалт, хамт олны үйл явдлууд, болон хөгжлийн хөтөлбөрүүдэд харилцааны бүхий л арга хэлбэрийг ашиглах шаардлагатай.



Жишээ 7 Филиппин

Сайхан ирээдүйн төлөө дохих нь

Филиппиний Бохол арал дээр орон нутгийн ХОТСЗ-ын хөтөлбөр сонсголын бэрхшээлтэй хүмүүст, гэр бүлийн гишүүдэд, хамт олонд дохионы хэлний сургалтыг зохион байгуулав. 2008 онд 8-68 насны, янз бүрийн амьдралтай 200 гаруй хүмүүс дохионы хэл сурч, одоо дохионы хэлийг гэр бүлийн гишүүд, найз нөхдөд нь зааж өгөв. Энэ санаачлага нь сонсголгүй хүмүүсийн соёлын ойлголтыг нэмэгдүүлэх, сонсголгүй хүмүүсийг хүндэтгэж харилцахыг дэмжих зорилготой хэрэгжсэн. Дөрвөн долоо хоногийн сургалтын төгсгөлд сургагч багш нар (ихэнх нь насанд хүрсэн сонсголгүй хүмүүс)-ыг орон нутгийн их сургуульд дохионы хэлний сургалт зохион байгуулахыг урив. Их сургууль сургалт явуулсны төлөө тэдэнд төлбөр төлөв. Хамгийн нэртэй их сургуулийн гурван оюутнууд одоо ХОТСЗ-ын төсөлд ахлах ангийн сонсголгүй оюутнуудад багшаар ажиллаж байна.



Өөрөө өөрийгөө өмгөөлөхөд дэмжлэг үзүүл

ХОТСЗ-ын хөтөлбөр дараах зүйлүүдийг хийх ёстой. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс юу хийхийг хүсч байгааг асуух;
- Хүмүүст хөгжлийн бэрхшээлийнх нь талаар мэдээлэл өгөх;
- Хүмүүст хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварыг заах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрх, хариуцлагын талаар мэдээлэл өгөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ХОТСЗ-ын хөтөлбөрийн шийдвэр гаргах явцад хамруулах
- Хүмүүст тэдний эргэн тойронд байгаа үйлчилгээний талаар мэдээлэл өгөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг Өөрөө өөртөө туслах бүлэг болон тэдний байгаа газарт байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай холбох.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтнууд нь үр дүнтэй харилцагч нар гэдгийг баталгаажуул

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст адвокати үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэхийн тулд ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтнууд үр дүнтэй харилцагч байх ёстой. ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтнууд амьдралын өөр хэв маягтай, өөр суурь хүмүүжилтэй хүмүүстэй харилцах шаардлагатай болдог учир тэдэнд, ялангуяа ярилцаж байгаа сэдэв хэцүү, төвөгтэй, эсвэл маш мэдрэг асуудлаар ярилцаж байгаа бол, эсвэл ангид, эсвэл статус нь өөр бол, ижил хэллэгээр ярилцдаггүй бол, эсвэл бичиг үсгийн түвшин өөр байвал, маш тодорхой мэдээлэл өгч харилцах шаардлагатай. ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтнууд дараах зүйлүүдийг хийх ёстой. Үүнд:

- Харилцахад ээлтэй орчин үүсгэх, харилцааны бэрхшээлтэй хүмүүсийг өөрсдийгөө илэрхийлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- Орон нутгийн хүмүүстэй нэгэн адил хэлээр, эсвэл ижил аялгаар ярих;
- Орон нутгийн дохионы хэлийг мэдэх, мөн өөрөөр хэрхэн харилцахаа мэдэх;
- Орон нутгийн соёл, анги, давхрагын ялгааг ойлгох, хүндлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эмэгтэйчүүд болон бусад анхаарлаас гадуур байгаа бүлэгтэй хүндэтгэлтэйгээр харилцаж, үүргээ сайн биелүүлэх;
- Эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа болон нийгмийн салбарын гол хүмүүстэй байнга уулзаж, уулзалтын үеэр харилцан ярилцлага зохиох;
- Олон нийттэй харилцахад хэвлэл мэдээллийн хэрэгслийг хэрхэн ашиглахаа мэдэх.



Хамт олныг хөдөлгөх

Танилцуулга

Хамт олныг хөдөлгөөнд оруулах нь нөөц бололцоо, үйлчилгээг хүргэхэд туслахын тулд, мөн тогтвортой байдал, өөрөө итгэлтэй байхад хамт олны оролцоог бэхжүүлэхийн тулд, тодорхой нэг хөтөлбөрийн талаарх ард түмний ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд аль болохоор олон гол хүмүүсийг нэгтгэх явц юм. Хамт олны өнцөг булан бүрээс цугларсан хүмүүс хэрэгцээгээ тодорхойлох, шийдвэр гаргахад оролцохдоо нийтлэг зорилготой байж, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож чадвал их зүйлд амжилт олж чадна. Хамт олныг хөдөлгөх нь хамт олныг эрх мэдэлжүүлж, тэд өөрсдийнхөө хөгжилд санаачлагатай хандаж, хяналт тавихад нь тусалдаг.

Хамт олон дэмжиж, нийгмийн олон салбар өөрчлөлтийн явцад идэвхтэй оролцвол хөгжлийн бэрхшээлийг гольдролд оруулахад бага ч гэсэн дэвшил гарна (11). ХОТСЗ-ын хөтөлбөр энэхүү хамт олныг хөдөлгөх аргыг гол хүмүүсийг, тухайлбал: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд, өөрөө өөртөө туслах бүлгүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд, хамт олны гишүүд, орон нутгийн эрх бүхий байгууллагууд, орон нутгийн манлайлагч нар, шийдвэр гаргагч нар, болон бодлого боловсруулагчдыг цуглуулах, хамт олонд тулгарч байгаа саад бэрхшээлд анхаарлаа хандуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олон дотроо эрхээ тэгш эдэлж, боломжоо ашиглаж амжилттай нийгэмшихэд нь баталгаажуулах зэрэгт ашиглаж болно.

Энэ элемент нь ХОТСЗ-ын хөтөлбөр өөрчлөлт хийхэд хүмүүсийг хэрхэн хамтран ажиллуулж, нэгтгэх талаар анхаарлаа хандуулна.

ЗУРАГ 1: Хамт олныг хөдөлгөх дөрвөн шат



Манлайлалаар дамжуулж эрх мэдэлжүүлэх

Колумб-д олон хотын захиргаанууд орон нутгийн засгийн газраас санхүүждэг, удирддаг ХОТСЗ-ын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Олон хөтөлбөрүүд тогтвортой биш, мөн хамт олон өөрсдөө эзэмшиж чаддаггүйг харгалзан үзэж, 2002 онд олон жилийн туршлагын дараа нэг засгийн газар нэгэн туршилтын төслийг (ФУНДИСКА- Каукасиягийн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сан) Колумбын хойд хэсгийн Каукасиягийн хотын захиргаан дээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

ФУНДИСКА-ийн гол зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ХОТСЗ-ын хөтөлбөрт манлайлалын үүрэгтэй оролцох, өөрийнхөө амьдралыг төлөвлөх, хянахад идэвхтэй үүрэг гүйцэтгэх зэргээр эрх мэдэлжүүлэхэд оршино. ФУНДИСКА олон хүмүүсийг хөдөлгөөнд оруулж, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эцэг эх, асран хамгаалагч, ажлаас халагдсан хүмүүс, уугуул хүмүүс, хамт олны гишүүд, хамт олны манлайлагчдыг нэг дор цуглуулж чадсан.

Одоо ФУНДИСКА 218 гишүүнтэй, ХОТСЗ-ын хөтөлбөрийн 20 сайн дурын идэвхтэнтэй болсон. Анх ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээ илрүүлэх, тэдэнд болон гэр бүлийн гишүүдэд шаардлагатай тусламж дэмжлэгийг үзүүлдэг байв. Тэд өөртөө итгэлтэй болоход нь, гэр бүлийг хамруулахад ажилладаг бөгөөд эрүүл мэнд, болосворол, хөдөлмөр эрхлэлтийн салбарт үйлчилгээг хүртээмжтэй болгоход ажилладаг.

ФУНДИСКА-д хэд хэдэн саатал байсан. Тухайлбал зарим гишүүд нь өөрийнхөө сонирхлыг бүлгийн сонирхлоос урьтал болгож байсан, хотын захиргааны түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд хандах нөөц бололцоо дутмаг, институт/үйлчилгээ үзүүлэгчид хөгжлийн бэрхшээлийн асуудалтай хандахдаа тийм ч мэдрэг ханддаггүй.

Гэхдээ цаг хугацаа өнгөрч, ФУНДИСКА-гийн үр нөлөөгөөр эдгээр бэрхшээлүүдийг даван туулж, динамик, сайн зохион байгуулалттай сан болж хөгжсөн. Хамт олныг хөдөлгөх тасралтгүй стратегийн үр дүнд ФУНДИСКА хамт олныг хөгжлийн бэрхшээлд сонирхолтой, түүнд оролцдог болгосон. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний хамт олныг ойрхон хамт байлгаж, хамт олны манлайлагчдыг орон нутгийн эрх бүхий байгууллага дээр хөгжлийн бэрхшээлийн асуудлын талаар тэдний өмнөөс ярихыг (адвокаци) дэмжсэн.



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд тохиолдож байгаа саад бэрхшээлийг арилгах, мөн хамт олны үйл ажиллагаанд хамруулахад идэвхтэй үүрэг гүйцэтгэх орон нутгийн хамт олныг эрх мэдэлжүүлнэ.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд хандах сөрөг хандлагыг өөрчилж, хамт олон ХОТСЗ-ын хөтөлбөрийг дэмжиж хөгжлийн бүх салбарт хөгжлийн бэрхшээл гольдролд орж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд хамт олныг хөдөлгөхөд оршино.

Хүсч буй үр дүн

- Хамт олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг мэдэж, тэдний амьдралын чанарыг сайжруулах урам зоригтой болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүдэд тохиолддог хамт олон доторх саад бэрхшээл арилж, багасна.
- Хамт олон ХОТСЗ-ын хөтөлбөрийн талаар, мөн ХОТСЗ-ын хөтөлбөрийг тогтвортой байлгах, түүнийг боловсронгуй болгоход хамт олны нөөц бололцоог хэрхэн ашиглах талаар мэдлэгтэй болно.
- Хамт олон ХОТСЗ-ын хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, удирдахад оролцоно.

Гол ойлголтууд

“Хамт олон” тодорхойлолт

Хамт олонд түшиглэн сэргээн засах гэдэг нэр томъёо нь хамт олныг ХОТСЗ-ын хөтөлбөрт гол үүрэг гүйцэтгэхийг санал болгодог билээ. “Хамт олон”-ыг нийгмийн ямар нэгэн хэлбэрийн зохион байгуулалт болон холбоо нэгдэлд хамтдаа амьдарч буй хүмүүс гэж тодорхойлж болох юм. Гэхдээ ерөнхий хамт олон нэгэн төрлийн байдаг бол харин гишүүд нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын онцлог байдал, сонирхол, хүсэл тэмүүллийн хувьд өөр өөр байдаг (12). Тухайлбал: “уламжлалт” хөдөөгийн хамт олон, гишүүд нь өөр өөр үндэстэн ястны бүлэгт хамаарагддаг бөгөөд тэд өөр хэлээр ярьж, өөр шашин шүтэж, өөр соёлтой байдаг.

Хамт олны гол хүмүүс

Хамт олон дотор янз бүрийн хүмүүс, бүлэг, байгууллагууд байдаг ба тэдгээрийн ихэнх нь ХОТСЗ-ын хөтөлбөрт чухал гол хүмүүс болох боломжтой байдаг. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд, хөршүүд, найз нөхөд, өөрөө өөртөө туслах бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон орон нутгийн эрх бүхий байгууллагууд хамрагдана.

Менежментийн бүлэг (энэхүү удирдамжийн танилцуулгын хэсэг)-т тэдгээр гол хүмүүсийн үүрэг, хариуцлагын талаар илүү мэдээллийг агуулсан буй. Хамт олон дотор зарим нэг гол хүмүүс бусаддаа (тухайлбал: омог, шашин, улс төрийн манлайлагч) илүү нөлөө үзүүлдэг, мөн хамт олны талаар шийдвэр гаргахад илүү эрх мэдэлтэй байдаг гэдгийг санаж байх хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээл нь хамт олны асуудал

Хамт олны хөгжил нь эрүүл мэнд, боловсрол, ус, ариун цэвэр, орон гэр, тээвэр, байгаль орчинтой хамаатай байдаг бөгөөд энэ бүгд нь хөгжлийн бэрхшээлийн тархац болон өвчлөлтөнд нөлөө үзүүлдэг (Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсгийг үзнэ үү). Тиймээс хөгжлийн бэрхшээл нь хамт олны хамгийн чухал асуудал боловч түүнийг ихэнхдээ үл ойшоодог.

Ихэнх хамт олонд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн амьдралын чанарт нөлөө үзүүлдэг саад бэрхшээлүүд байдаг. Тухайлбал орчны/хөдөлгөөний, хандлагын, соёлын, үйлчилгээний, тогтолцооны, мөн бодлогын түвшний саад бэрхшээлүүд байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст болон тэдний гэр бүлийн гишүүдэд тулгардаг саад бэрхшээлүүдийн талаар энэхүү Удирдамжийн бүрэлдэхүүн хэсгүүдэд илүү нарийвчлан тодорхойлсон буй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд ихэнхдээ нөлөөлдөг саад бэрхшээлүүдийг ХОТСЗ-ын хөтөлбөр ойлгож, тэднийг илрүүлэх нь чухал.

Хамт олныг хөдөлгөх


Хөгжлийн салбарт хамт олныг зөвхөн тусламж, үйлчилгээг хүлээн авагч биш, тэднийг хөгжлийн үйл ажиллагаанд манлайлагч байхад нь илүү анхаарлаа тавьдаг билээ. Хамт олон өөртөө тохиолдсон бэрхшээлийг илүү сайн шүүж, асуудлыг шийдэх тохиромжтой арга хэмжээ авах чадвартай байдаг. ХОТСЗ нь хамт олонд түшиглэсэн хамруулан хөгжүүлэх стратеги учир хамт олны оролцоо чухал. Тухайлбал хамт олны үгийг сонсож, тэдний амьдралд нөлөөлөх үйл ажиллагаа болон шийдвэр гаргахад оролцуулах гэх мэт (Танилцуулга хэсгийг уншина уу).

Хамт олныг хөдөлгөх нь ХОТСЗ-ын хөтөлбөрийг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил хэрэг төдийгүй хөгжлийн бэрхшээлийг хэн нэгний ажил хэрэг болгоход ашиглаж болдог стратеги юм. Хамт олны гол хүмүүсийг ХОТСЗ үйл ажиллагааг хамруулан хөгжүүлэхэд чиглүүлэхэд нь ХОТСЗ-ын хөтөлбөр энэ стратегийг ашиглаж болно. ХОТСЗ-ын хөтөлбөр хамт олныг өөрийнхөө ажилд хамруулж чадвал санхүүжилт, тусламж дэмжлэг дууссан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдэд зориулсан ашиг үргэлжилж байх болно.

Жишээ 9 ЭТИОП

Хамт олныг урамшуулах гүүрийг барих нь

Этиопын Адаама мужийн ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан гол гаталдаг гүүр эвдэрсэн байхыг олж харжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэ гүүрээр гарахад хүндрэлтэй байдаг байсан төдийгүй бусад нь ч гэсэн хүндрэлтэй тулгарч байжээ. Жишээ нь нэг залуу хүү гол гатлах гэж байгаад гараа гэмтээсэн. ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан сургууль болон орон нутгийн захиргаатай харилцаж орчин тойрныхоо дэд бүтцийг сайжруулах хороо байгуулав. Хороо хамт олныг мөнгөн болон биеэрээ хөрөнгө оруулалт оруулахаар хөдөлгөөнд оруулав. Орон нутгийн захиргаатай хамтарч ажилласны үр дүнд шинэ гүүртэй боллоо. Шинэ гүүртэй болсны дараа орон нутгийн захиргаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж илүү ихийг хийх урам зоригтой болсон ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулж сургуулийн дэд бүтцийг сайжруулахаар шийдэв. Хамт олон маш агуу том нөөц бололцоо төдийгүй амьдарч байгаа орчин тойрноо сайжруулах урам зоригтой нөөц бололцоо гэдгийг ХОТСЗ-ын хөтөлбөр олж мэдэв. Бага нөөц бололцоогоор ч гэсэн их амжилтанд хүрдэг бөгөөд ялангуяа хамт олон өөрөө санаагаа гаргасан бол бүр ч ихийг бүтээж чаддаг.



Санал болгож буй үйл ажиллагаанууд

Хамт олныг хөдөлгөх нь тасралтгүй үргэлжилдэг явц учир энэ элемент нь алхам тутамд удирдамж өгдөггүй боловч өргөн хүрээтэй, зохион байгуулалттай үйл ажиллагаануудыг санал болгодог. Үйл ажиллагаануудын ихэнх нь энэхүү Удирдамжийн бусад хэсгийнхтэй нийтлэг, ялангуяа Менежмент бүлэгтэй нийтлэг.

Хамт олны талаар олж мэд

Хөгжлийн бэрхшээлийн асуудалд, хөгжилд дэмжлэг үзүүлэхэд мөн ХОТСЗ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамт олныг хөдөлгөхийн тулд хамт олны талаар мэдлэгтэй байх нь чухал. ХОТСЗ-ын хөтөлбөр хүмүүсийн амьдарч байгаа нөхцөл байдлыг (хөдөлгөөн/бие бялдар, эдийн засаг, нийгэм, улс төр, соёл) болон хамт олонд тулгарч байгаа асуудлын талаар ойлголтыг боловсруулах ёстой. Нөхцөл байдлын судалгаа хийх үр дүнтэй нэг арга бөгөөд нөхцөл байдлын судалгааг Менежмент бүлэгт илүү нарийвчилсан тодорхойлсон байгаа.

Хамт олны эрх мэдлийн бүтцийг нээж илрүүлэх нь хамт олныг хөдөлгөх гол үйл ажиллагаа юм. Эрх мэдлийн албан ёсны байр байдалд байгаа хүмүүс,

тухайлбал орон нутгийн захиргааны манлайлагч, хамт олны бүлгийн манлайлагч, эсвэл байгууллага (өөрөө өөртөө туслах бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага)-ыг болон хөгжлийн салбарт нөлөө үзүүлэх өөр хэн нэгнийг (тухайлбал боловсролын салбарт багш гэх мэт) олох ёстой. ХОТСЗ-ын хөтөлбөрийн хувьд тэдгээр эрх мэдлийн бүтцийг сурах нь чухал. Учир нь эрх мэдэлтэй хүмүүс болон нөлөө нь хамт олны санаачлагыг дэмжиж, хүмүүсийг хөдөлгөөнд оруулах чадвартай байдаг.



Хамт олны талаар суралцаж байх үедээ хамт олныг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд хандах хандлага болон зан авирыг мэдэж авах нь чухал. Хүмүүсийн хэн нэгэнд хандах зан авир нь тэдний хандлагыг илэрхийлдэг. Тэдний зан авирыг ажигласнаар тэд хүндэтгэлгүй, зөөлөн, дээрэнгүй, эсвэл хайнга үл ойшоосон байдлаар харьцаж байгаа эсэхийг мэдэх

Хамт олон дотор итгэл үнэмшил, ил тод байдлыг бий болго

ХОТСЗ-ын хөтөлбөр хамт олны гол хүмүүстэй итгэлцэл бий болгож, ил тод байхад цаг зарцуулах нь чухал. ХОТСЗ дараах зүйлийг хийх ёстой. Үүнд:

- Хамт олонтой ажиллахад орон нутгийн манлайлагчдаас зөвшөөрөл ав.
- Хамт олон дотор идэвхтэй, ил тод бай. Мөн бусад гол хүмүүсийн үйл ажиллагааг дэмж.
- Олон хүмүүсийг мэдэж, тэдний асуудлыг ойлгож, тэдэнтэй ажиллах хамгийн сайн аргыг олж авахын тулд тэдэнтэй холбоо тогтоо.
- ХОТСЗ-ын хөтөлбөрийн талаарх чухал мэдээлэл, шинэ мэдээллийн талаар байнга ярь.
- Шударга, ил тод бай. Хийж чадахгүй зүйлээ битгий амла.

Хамт олны ойлголтыг нэмэгдүүл

Хамт олныг амжилттай хөдөлгөөнд оруулж, хөгжлийн бэрхшээлийн талаарх санал санаачлага дээр дэмжлэг авахын тулд эхлээд хамт олны гишүүдийн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж, хэрхэн тохиолддог, юу хийж болох талаар ойлгуул. Ихэнх хүмүүс хөгжлийн бэрхшээлийн талаар хязгаарлагдмал ойлголттой байдаг учир хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар сөрөг хандлагатай, сөрөг зан авир гаргадаг. Тэд хөгжлийн бэрхшээлийг эрүүл мэндийн асуудал гэж ойлгодог бөгөөд зөвхөн харамсаж, буруу ойлгоход хүрдэг.

Хамт олонд хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт өгөх олон арга бий. Тухайлбал: бүлгийн ярилцлага, дүрд хувирч тоглох, дүрстэй эсвэл бичигтэй зурагт хуудас, түүх ярих, дуу дуулах, жүжиг тоглох, хүүхэлдэйн үзүүлбэр, зурагт хуудас, кино, радио гэх мэт зүйлүүдийг ХОТСЗ-ын хөтөлбөр ашиглаж болно.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд дараах зүйлүүдийг санаж байх ёстой. Үүнд:

- Илгээх үг (мессеж) энгийн байх ёстой.
- Хэрэглэж байгаа арга нь орон нутгийн соёлд тохирч байх ёстой.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шууд хамруулбал ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагаа илүү сайн болдог.
- Хандлага, зан авир өөрчлөгдөхөд цаг хугацаа ордог. Энэ бол үргэлжлэх явц юм.

Жишээ 10 Кени

Хандлага өөрчлөгдсөн

Калум Кенийн хөдөө гэр бүлтэйгээ хамт амьдардаг унадаг өвчтэй залуу хүү юм. Калум нэг удаа унахдаа гал дээр унаж түлэгдсэний улмаас хөлд нь контрактур /гажигтай болж богиносох/ үүсч, хөдөлгөөний бэрхшээлтэй болсон. Түүнийг бусдаас нууж, тусгаарласны улмаас түүний чадварууд нь тухайлбал харилцааны чадвар нь удааширсан. Калумын гэр бүл нь хүүгийнхээ хөгжлийн бэрхшээлээс болоод хамт олон дотроо шоовдорлогдсон төдийгүй тэд үндсэн хэрэгцээгээ ч хангахад хүнд байв.

Калумыг тухайн дүүрэгт зохион явуулсан хөгжлийн бэрхшээлийн судалгааны үеэр илрүүлсэн. ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан Калумыг эрүүл мэндийн төв рүү аваачиж, түүний уналтыг хянах эм авах боломжтой болгов.

Кенийн Анагаах ухааны эрдэм шинжилгээний Институт (КАУЭШИ) Кенийн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмлэг (КХБХН)-тэй хамтарч Калумыг мэс засалд оруулж, түүний контрактурыг засав. Мөн Калумын чадварыг сайжруулах үндсэн эмчилгээг хийв. КАУЭШИ-ийн ажилтнууд сар бүр Калум болон түүний гэр бүлийг хянаж байв.

Мөн хамт олонд хөгжлийн бэрхшээлийн талаар, боломжит шалтгаан зэргийн талаар мэдээлэл олгосон. КАУЭШИ-ийн ажилтнууд хүмүүст уналт таталт бол хүнд халддаггүй, ямар нэгэн далдын хүч хөгжлийн бэрхшээлийг бий болгодоггүй, хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд болон тэдний гэр бүлийн гишүүдэд туслах үүрэгтэй гэдгийг ойлгуулахад нь тусалсан. Хамт олны гишүүдтэй байнга тогтмол уулзах нь хүмүүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст болон тэдний гэр бүлийн гишүүдэд хандах хандлага өөрчлөгдөхөд тус болдог. Хамт олны зарим гишүүд нь Калумын гэр бүлд байшин барьж өгчээ.



Хамт олныг оролцоход нь дэмж

ХОТСЗ-ын хөтөлбөр хамт олны гол гишүүдийг хөгжлийн бэрхшээлийн асуудалд анхаарлаа хандуулж, хамруулан хөгжүүлэхэд хамтран ажиллахыг дэмжих нь чухал. Хамт олны төрөл бүрийн хүмүүсийг хамт олны үйл ажиллагаанд, өөрчлөлтөнд хамтран оролцохыг дэмжих хэрэгтэй. ХОТСЗ-ын хөтөлбөрийн хүмүүст ХОТСЗ хандлага нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиг хүртэх бус нийт хүмүүс ашиг хүртэх стратеги юм гэдгийг ухуулж ойлгуулах хэрэгтэй. Хамт олны гишүүдийг ХОТСЗ стратеги (ойлголт, философи, зорилго, зорилт) руу, мөн хамт олонд хэрхэн тусалж байгаад чиглүүлж, эрчимжүүлбэл энэ нь чухал үйл ажиллагаа болдог.

Хамт олны гол хүмүүсийг юу урамшуулж байгааг ойлгох нь чухал. Эхэн үедээ хамт олны гол хүмүүсийг урамшуулах, сонирхлыг нь бий болгохийг хөхүүлэн дэмжих хэрэгтэй байж болно. Гэхдээ хүмүүс үйл ажиллагаанд оролцохын чухлыг, мөн оролцсоноор ямар нэгэн шагнал, урамшуулал авснаас илүү сэтгэл ханамж авахын чухлыг ХОТСЗ-ын хөтөлбөр баталгаажуулж ажиллахыг санал болгож байна. Тухайлбал ХОТСЗ-ын хөтөлбөр хамт олны гол хүмүүсийг (хамт олны манлайлагч) хөтөлбөрийн үйл ажиллагааг ажиглахыг урьж, эсвэл ХОТСЗ-ын хөтөлбөр сайн хэрэгжиж байгаа газарт очиж үзэх ажлыг зохион байгуулж болно.

Хамт олныг оролцох боломжийг бий болго

Хамт олон дотор өөр өөр үзэл бодолтой, санаа оноотой, өөр зүйлийг нэн тэргүүнд авч үздэг, өөр өөр ажил хийдэг гол хүмүүс байдаг. Хамт олныг хөдөлгөөнд оруулахад бүх гол хүмүүст нэгэн зэрэг хандах шаардлагагүй. Харин ХОТСЗ-ын хөтөлбөрийн зарим нэгэн ажиллагаанд зарим хүмүүсийг оролцуулж болно.

Хамт олны хэрэгцээ, эрх, нөөц бололцоо, чадавх, болон үүргийн талаар ойлголт нэмэгдүүлэхэд туслахын тулд нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор гол хүмүүсийг ХОТСЗ-ын хөтөлбөрийн үйл ажиллагаануудад урьж болно. (Менежмент бүлгийг үзнэ үү)

Хамт олны гол хүмүүсийг оролцуулахгүй байж болох ямар нэгэн саад бэрхшээлийг ХОТСЗ-ын хөтөлбөр олж илрүүлж, тэдгээр саад бэрхшээлийг даван туулахад гол хүмүүстэй хамтран ажиллах хэрэгтэй. Оролцоог хангахад дараах саад бэрхшээлүүд байж болно: цаг хугацааны хязгаартай байдал, соёлын хязгаарлалт, гэр бүлийн хариуцлага, ажлын хариуцлага, эсвэл өөртөө итгэлтэй биш байх гэх мэт.



Холбогдох гол хүмүүсийг хамтад нь нэгтгэ

Шаардлагатай үйл ажиллагаа болон өөрчлөлтийн талаар зөвшилцөх, ярилцахад гол хүмүүсийг нэгтгэх нь чухал юм. Гол хүмүүсийг уулзалтанд тогтмол урих нь дээрх үйл ажиллагааг хийх сайн арга нь байна. Уулзалтын үед эмзэг бүлгийн гишүүд эрх тэгш оролцож, эрх мэдлийн тэнцвэртэй байдлыг хадгалах нь чухал.

Хамт олны чадавхийг бэхжүүл

Хамт олны гишүүд ХОТСЗ-ын хөтөлбөрт гол үүрэг гүйцэтгэх бөгөөд тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд сургалтанд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Чадавх бэхжүүлэх сургалт Менежментийн бүлэгт илүү дэлгэрэнгүй орсон учраас энд нарийвчилж ярьсангүй.

Амжилтаа тэмдэглэ

Хамт олны гол хүмүүсийг тасралтгүй оролцуулж, урамшуулж байхын тулд тэдний хувь нэмрийг болон олсон ололт амжилтыг нь сайшааж байх нь чухал. Баяр тэмдэглэх нь хамт олонд дахин хүч энерги өгч, хамт олны дотноос болон гаднаас оролцох сонирхол нь ихэсч, ХОТСЗ-ын хөтөлбөрт дэмжлэг болж хамруулан хөгжүүлэх боломжийг олгодог.

Улс төрийн оролцоо

Танилцуулга

Улс төрийн нарийвчилсан тодорхойлолтыг засгийн газар, улс төрчид эсвэл улс төрийн намуудын үйл ажиллагаанаас лавлаж харж болно. Ерөнхий тодорхойлолт нь хүмүүс хоорондын, эрэгтэй эмэгтэй хүмүүс хоорондын, эцэг эх хүүхэд хоорондын, хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүмүүс хоорондын харилцаа, мөн хүний хоорондын харилцааны түвшин бүрт эрх мэдлийн үйл ажиллагаа юм.

Улс төрийн оролцоонд хүмүүс хоорондоо дэлхий ертөнцийн талаарх сэтгэгдлээ, түүнийг хэрхэн засаглах талаар үзэл бодлоо илэрхийлж, өөрсдийнхөө амьдарч байгаа газарт нөлөөлөх шийдвэр гаргахад оролцохыг оролдох зэрэг өргөн хүрээний үйл ажиллагаанууд багтдаг. Манай нөхцөл байдалд хувь хүний эсвэл гэр бүлийн түвшинд хөгжлийн бэрхшээл эсвэл нийгмийн бусад асуудлын талаар бодож эхлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, бусад бүлэг болон байгууллагуудад нэгдэх, орон нутгийн, бүсийн болон үндэсний түвшинд кампанит ажилд оролцох, улс төрийн албан ёсны явц, тухайлбал сонгуульд санал өгөх, улс төрийн намд элсэх, эсвэл сонгуульд оролцох зэрэг үйл ажиллагаанууд багтана.

Энгийн хүмүүс улс төрд оролцож болох ба хүн бүр, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үүнд оролцох эрхтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн 29-р зүйлд улс төрийн болон олон нийтийн амьдралд оролцох талаар дурдахдаа “Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг улс төрийн эрхээ бусдын нэгэн адил эдлэх боломжоор хангана” гэсэн байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс улс төрд оролцоход олон саад бэрхшээлүүд тулгардаг ба шийдвэр гаргах, өөрчлөлт хийхэд эрх мэдэл нь хязгаарлагдмал байдаг эсвэл тэднийг анхаарахгүй байдаг учраас тэдний ихэнх нь улс төрд оролцохгүй байхыг сонгодог байж болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог дэмжих нь эрх мэдэлжүүлэх явцын чухал хэсэг нь юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс олноороо оролцохгүй бол тэдний дуу хоолой сонсогдохгүй болж, эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, болон нийгмийн салбарт хүрэх хүртээмж нь хязгаарлагдах болно.



Гулугийн туршлага

Угандагийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үндэсний холбоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломжийг бий болгох талаар тэдний өмнөөс өмгөөлөх, тэднийг засгийн газар, иргэний нийгэм, олон нийттэй хамтран хөгжлийн бэрхшээлийн хөтөлбөрийн бодлого, төлөвлөгөө, хэрэгжилтэнд оролцуулах, хамруулах зорилгоор 1987 онд байгуулагдсан. Угандагийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үндэсний холбоо олон жилийн туршид улс төрийн лобби хийсний үндсэн дээр парламентын таван гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болсон. Мөн дүүргийн болон мужийн түвшинд орон нутгийн засгийн газарт олон зөвлөгч нар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болсон.

Бусад олон орны адил Угандад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой хууль журмууд байдаг. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай хуулийн зөвлөл 2003, Хөгжлийн бэрхшээлийн талаарх бодлого 2003, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай хууль 2006, Тэгш боломжийн тухай хууль 2007 зэрэг юм. 2006 оны хуулиар хүртээмжийн хангалт болон хуулийг хэрэгжүүлээгүй этгээдэд ногдуулах торгууль шийтгэлийн талаар зааж өгсөн.

Олон оронд иймэрхүү ижил хууль журмууд байдаг хэдий ч хэрэгжилт нь муу, олон нийт тэрхүү хуулийн талаар мэдлэггүй байдаг. “Хэрэв хэрэглэгчид ямар нэгэн гомдол гаргахгүй, өөрсдийнхөө эрхийг шаардахгүй бол холбогдох хууль журмууд цаасан дээр үлдэж, ашиг хүртэх ёстой хэрэглэгчид хэзээ ч ашиг хүртэхгүй үлдэнэ” гэдэгт Угандагийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үндэсний холбоо итгэдэг.

Угандагийн Гулу дахь Зууны хөдөөгийн хөгжлийн банк (The Centenary Rural Development Bank) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан дэд бүтцийг бий болгоогүй, байгууламж нь олон шаттай, хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүст, ялангуяа тэргэнцэртэй хүмүүс ороход хүндрэл учирдаг байв. Угандагийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үндэсний холбоо энэ асуудлаар банкны удирдлагуудтай уулзсан боловч барилгын орцыг засч хүртээмжтэй болгоход банк татгалзав.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай 2006 оны хуулиар “Олон нийтийн болон хувийн бүх байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй дэд бүтэц бий болгох, бие засах газрыг түгээмэл загвараар барих, байгуулах үүрэгтэй” гэж заасан байдаг. Энэ асуудлыг Угандагийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үндэсний холбоо шүүхэд өгч, олон удаа сонссоны эцэст шүүгч Холбооны талд шийдвэрийг гаргаж, Банк барилга байгууламжаа хүртээмжтэй болгож, Холбооны гаргасан зардлыг төлөхөөр шийдвэрээ гаргасан. Шүүхийн энэхүү хэргийн үр дүнд Зууны Банк бүх салбаруудынхаа бүх барилгыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй дэд бүтцийг бий болгосон.

Гулугийн туршлага нь хөгжлийн бэрхшээлийн хөдөлгөөнд сайн жишээ болсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүд эрхээ эдлэхийн тулд улс төрийн мэдлэгтэй байх хэрэгтэй. Хамт олон дотор өөрчлөлтийг хийх болон эрхээ эдлэхийн тулд хүмүүсийг хөдөлгөөнд оруулж, зохион байгуулах хэрэгтэйг мөн баталж байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиас....

30 дугаар зүйл. Улс төрийн үйл ажиллагаанд оролцох

30.1.Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

30.2.Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байна.

30.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох, төрийн аливаа албанд томилогдон ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэгтэй.

30.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил улс төрийн болон олон нийтийн амьдралд оролцох

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийг улс төрд оролцуулахын тулд, мөн оролцох боломжтой байлгахын тулд мэдээлэл, чадвар, мэдлэгтэй байх ёстой.
- Хөгжлийн бэрхшээлийн асуудал ил тод байвал улс төрийн шийдвэр гаргах явцад тэднийг оролцуулж, мөн тэд бодлого хөтөлбөр боловсруулах явцын төвд байна.

Хүсч буй үр дүн

- ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтнууд улс төрийн тогтолцооны талаарх мэдлэгээ нэмэгдүүлсэн байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд улс төрийн мэдлэгээ нэмэгдүүлсэн байна.
- Засгийн газар болон иргэний нийгэм хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн улс төрийн процесст оролцох эрх болон хөгжлийн бэрхшээлийн асуудлын талаар мэдлэгтэй болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг улс төрийн процесст оролцоход нь саад болж буй бэрхшээлүүд багасч, эсвэл арилна.

Гол ойлголтууд

Эрх мэдэл ба шийдвэр гаргах

Эрх мэдэл гэдэг нь мэдээлэлтэй хүмүүс сонголт хийж, чөлөөтэй үйл ажиллагаа явуулах чадвар юм. Эрх мэдэлтэй хүмүүс шийдвэр гаргадаг ба зарим нэгэн хүчин зүйлүүд, тухайлбал нас, хүйсийн гүйцэтгэх үүрэг, угсаатан, улс төрийн нэгдэл, эдийн засгийн нөхцөл байдал гэх мэтийн хүчин зүйлүүдээс илүү эрх мэдэлтэй хүмүүс бүх нийгэмд байдаг (13). Эрх мэдэл нийгмийн түвшин бүрт, гэр бүлээс засгийн газрын түвшин хүртэл байдаг. Улс төрийн оролцоонд хэн шийдвэр гаргах эрх мэдэлтэй, яагаад энэ эрх мэдэл тэдэнд байна гэдгийг ойлгох нь анхны шат юм.

Улс төрийн оролцоонд учрах саад бэрхшээл

Улс төрийн оролцоонд хүмүүст тулгарч болох саад бэрхшээлүүд нь энэхүү Удирдамжийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдэд дурдагдсан саад бэрхшээлүүдтэй адилхан. Товчид нь дүгнэж хэлэхэд дараах бэрхшээлүүдийг хамруулж болно.

- Ядуурал – ядуу хүмүүс ихэнхдээ амь зуух дээр анхаарлаа хандуулдаг. Тэднийг оролцуулахаас өмнө тэдний үндсэн хэрэгцээг хангах шаардлагатай байдаг. Тиймээс тэд цаг бага зарж, эсвэл оролцох сонирхолгүй байдаг.
- Боловсрол – мэдээлэл, мэдлэггүйгээр улс төрд утга төгөлдөр оролцоно гэдэг хүндрэлтэй.
- Нийгмээс тусгаар байдал – Улс төрийн оролцоог дэмжих, урамшуулах сүлжээ хязгаарлагдмал байдаг.
- Хувийн хүчин зүйл – Хүмүүст оролцох итгэл үнэмшил эсвэл урам зориг хязгаарлагдмал байдаг.
- Муу бодол ба ялгаварлан гадуурхалт – ихэнх бүлгүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар мухар сүжигтэй, айдастай, тохь тухгүй, эвгүй байдаг. Тиймээс тэдний оролцоог дэмжихгүй байж болно.
- Хөгжлийн бэрхшээлд ээлтэй явц дутмаг – дэд бүтэц, хүртээмжийн талаар саад бэрхшээлтэй байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс санал өгөх бүхээг хүртээмжгүй гэх мэтээс болоод оролцоход бэрхшээлтэй байж болно.
- Жишээ болох загвар дутмаг – ихэнх оронд улс төрийн өндөр албан тушаалд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гарсан нь цөөн байдаг.
- Хуулийн саад бэрхшээл – ихэнх оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс санал өгөхийг зөвшөөрдөггүй, тухайлбал сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс

ХОТСЗ-ын хөтөлбөрүүд ядуу амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцооны түвшин дээр бодит хандах нь чухал, мөн үйл ажиллагааг гарч болох саад бэрхшээлүүдийг тооцож зохион байгуулах хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээл нь улс төрийн асуудал болох нь

Засгийн газар, шийдвэр гаргагч нар нийгмийн саад бэрхшээл болон ялгаварлан гадуурхалт гэх мэтийн хөгжлийн бэрхшээлийн гол асуудлуудыг анхаарч үзээгүй байдаг учраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд маш олон сул талууд тулгардаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ нь бодлогын хөтөлбөрт, ялангуяа нөөц бололцоо дутмаг байгаа хэсэгт дээгүүр орж чаддаггүй. Тиймээс хөгжлийн бэрхшээлийг ерөнхий хөгжлийн үйл ажиллагаанд хамруулсан хөтөлбөр болон хөгжлийн бэрхшээлд зориулсан үйлчилгээ маш бага байдаг. Хөгжлийн бэрхшээлийн асуудлыг бодлогод тусгасан ч хэрэгжилт нь ихэнхдээ муу байдаг. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө нийгэмд маш олон саад бэрхшээлүүд байдаг.

Засгийн газар

Улс төрийн бүтэц, процессын талаар, эрх мэдэл хэрхэн урсдагийг, мөн тэд нарт хэрхэн нөлөөлдгийг ойлгох зэргээр засгийн газар хэрхэн ажилладагийг мэдэх нь өөрчлөлт хийх, нэгдэл эвсэл байгуулах зэрэг адвокати хийхэд хэрэгтэй байж болно. Засгийн газарт гурван улс төрийн засаглал байдаг: хууль тогтоох засаглал (парламент/чуулган), гүйцэтгэх засаглал (засгийн газар ба иргэний үйлчилгээ), шүүх засаглал (шүүх). Улс орнууд засаг захиргааны нэгжүүдэд хуваагддаг ба засгийн газрын хэд хэдэн түвшин байдаг: орон нутаг, дүүрэг, бүс, үндэсний. Түвшин бүрт эдгээр улс төрийн засаглалууд нь хуулийг баталдаг хууль тогтоох хүмүүсийг ардчилсан зарчмаар сонгодог байж болно. Хууль тогтоох улс төрийн засаглалыг орон нутгийн хүмүүс сонгоно. Орон нутгийн түвшинд энэ нь тосгоны зөвлөл байж болно, дараа нь дүүргийн эсвэл бүсийн чуулган, дараа нь үндэсний чуулган/парламент байна.

Улс төрийн квот

Улс төрийн төлөөллийг баталгаажуулахын тулд олон оронд орон нутаг, бүс, үндэсний түвшинд сонгогдох хүмүүст тодорхой хувийн суудал, эсвэл эмэгтэйчүүд, угсаатны цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг анхаарлаас гадуур байдаг хүмүүст зориулж засгийн газрын ажлын хувийг нөөцөлдөг. Үүнийг бид “квот”, “баталгаа өгсөн үйл ажиллагаа” эсвэл “эерэг ялгаварлан гадуурхалт” гэж нэрлэдэг.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан нь улс төрийн тогтолцооны ойлголттой байх

ХОТСЗ-ын хөтөлбөр түншлэл болон өөрчлөлт хийх нөлөөллийг бий болгохын тулд засгийн газар хэрхэн ажилладагийг амьдралд дээр ойлгох шаардлагатай. Тэд дараах зүйлүүдийг хийж ойлголттой болж болно:

- Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой бодлого, гол хууль дүрэм, болон хөгжлийн салбаруудыг илрүүлж;
- Засгийн газрын үүрэг болон хэлтэс, алба бүрийн хариуцах ажлыг олж мэдэж – аль хэлтэс, алба юуг хариуцдаг, хэн шийдвэр гаргах эрх мэдэлтэй гэх мэт

- Орон нутгийн түвшин дэх улс төрийн бүтцийг олж мэдэж – засгийн газрын шийдвэр энэ түвшинд хэрхэн хүрдэг, шийдвэр гаргахад орон нутгийн эрх мэдэл байгаа эсэх гэх мэт
- Хувь хүний харилцаа холбооноос үл хамааран сөрөг хүчний хүмүүс болон улс төрийн төлөөлөгчидтэй байнга уулзах; ХОТСЗ-ын хөтөлбөр нь ямар нэгэн намтай холбогдох эсвэл холбогдох гэж бодох эсвэл эрх мэдэлд нь түшиглэж болохгүй буюу хөтөлбөр нам бус байх ёстой.

Улс төрийн мэдлэгийн хөгжлийг чиглүүл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ихэнх хүмүүс, ялангуяа ядуу хүмүүс улс төрийн талаарх ойлголтын түвшин муу байдаг. Тухайлбал: тэд санал хэрхэн өгөхийг мэдэхгүй, хөгжлийн бэрхшээлийн эрхийн талаар үндэсний хууль дүрэм эсвэл Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци гэх зэрэг олон улсын конвенциуд байдаг гэдгийг мэдэхгүй байж болно. Улс төрийн оролцоог дэмжихийн тулд ХОТСЗ-ын хөтөлбөр нь дараах зүйлүүдийг хийж болно:

- Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүмүүсийг бичиг үсэгтэй болгох хөтөлбөрт хамруулах (Боловсролын бүрэлдэхүүн хэсгийг үзнэ үү)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг адвокати болон эрхэд суурилсан сургалтуудад хамруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олны өмнө ярьж сурах, асуудлыг шийдвэрлэх, кампанит ажил зохиох гэх мэт улс төрийн оролцооны ашигтай чадваруудыг сурч болдог өөрөө өөртөө туслах бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай холбох
- Хүүхдүүд болон өсвөр насныхан үйл ажиллагаанд оролцож, өөрсдийнхөө үзэл бодлыг илэрхийлэх, бодох, шийдвэр гаргах, өөрсдийнхөө хийж байгаа үйл ажлын үр дагаварыг ойлгодог болохыг нь баталгаажуулах

Улс төрийн тогтолцоонд хөгжлийн бэрхшээлийн мэдлэгийг нэмэгдүүл


Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ихэнхдээ тоохгүй байх, засгийн газрын түвшинд мэдлэг дутмагаас болоод тэднийг ихэнхдээ ялгаварлан гадуурхаж, хамруулахгүй байдаг. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг улс төрд оролцох боломж олгох бас нэгэн стратеги нь улс төрийн тогтолцоонд хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх явдал юм. Дараах үйл ажиллагаануудыг хийж болно:

- Хууль, дүрэмд хөгжлийн бэрхшээл хамрагддаг гэдгийг орон нутгийн улс төрийн төлөөлөгчдөд болон хүнд сурталтнуудад ойлгуулах
- Орон нутгийн зөвлөлтэй хамтарч хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сургалтанд манлайлж оролцох нь чухал.
- ХОТСЗ-ын хөтөлбөр болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зохион байгуулж буй үйл ажиллагаануудад улс төрийн манлайлагчид болон төлөөлөгчдийг хамруулах. Тухайлбал ХОТСЗ-ын хөтөлбөр шинээр эхлэх гэж байгаа газарт тэднийг нээлтэнд урих, Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдрийн арга хэмжээнд урих гэх мэт. Улс төрийн манлайлагчид болон төлөөлөгчид эдгээр хүмүүсийн сайн сайхан байхад хувь нэмрээ оруулагчид гэж харагдахыг хүсдэг учир ХОТСЗ-ын хөтөлбөр энэ давуу талыг

Улс төрийн явцад оролцох боломжийг чиглүүл

Улс төрийн оролцоонд тоолж барамгүй их саад бэрхшээлүүд байдгийг ХОТСЗ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид ойлгох ёстой. Эдгээр саад бэрхшээлийг багасгах, эсвэл арилгахад өөрөө өөртөө туслах бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон бусад байгууллагатай хамтарч ажиллаж болно. Дараах үйл ажиллагаануудыг хийж болно:

- Сонгууль болох газар болон сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцох боломжийг хангах талаар орон нутгийн эрх бүхий байгууллагад зөвлөмж хүргүүлэх – Барилга байгууламжийн дэд бүтцийг хангасан, хүртээмжтэй байх, санал авах материалууд нь ойлгоход хялбар, төрөл бүрийн бэрхшээлтэй хүмүүс түүнийг нь ашиглаж чаддаг байх гэх мэтийг зөвлөмжинд тусгана.
- Сонгуулийн үндэсний хороо болон адвокати өгдөг байгууллагуудыг хөгжлийн бэрхшээлтэй санал өгөх гэж буй хүмүүст тэдний санал өгөх эрхийн талаар болон тэднийг оролцоход ямар төрлийн тусламж дэмжлэг байгаа талаар мэдээлэл хийхийг дэмжих
- Улс төрийн манлайлагчид болон намуудыг ухуулах материалаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиглах боломжтойгоор, хүртээмжтэйгээр хэвлэхийг дэмжих
- Хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийг сонгууль өгөх газарт хүрэхэд нь туслах тээврийн хэрэгслүүдийн сонголтуудыг эрж хайх
- Анхаарлаас гадуур байгаа хүмүүст зориулсан улс төрийн суудал/засгийн газрын ажил байгаа эсэхийг олж илрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг энэ давуу талаа ашиглахыг нь дэмжих



Жишээ 12 Монгол

Сонгуулийн тухай хуулиас....

87.4.Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд нэг байна.

87.5.Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчдын тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.

87.6.Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.

Үүнтэй холбогдуулан Монголын Хараагүй иргэдийн үндэсний холбоо хараагүй хүмүүсийг нууцаар, бие дааж саналаа өгөх боломжийг бий болгох зорилгоор саналын хуудсан дээр хэрэглэх Брайл хавтас ашиглаж 2016 оны УИХ-ын сонгуулиар туршсан.

Өөрөө өөртөө туслах бүлэг

Танилцуулга

Өөрөө өөртөө туслах бүлэг нь нийтлэг тулгарсан бэрхшээлээ хамтран даван туулах зорилготой албан бус бүлэг хүмүүс юм. Өөртөө туслах гэдэг нь нэг хувь хүнд анхаарлаа хандуулдаг бол өөрөө өөртөө туслах бүлгийн нэг чухал шинж чанар нь хүмүүс бие биедээ харилцан туслах санаа юм. Тухайн нөхцөл байдал болон хэрэгцээнээс шалтгаалж өөрөө өөртөө туслах бүлэг нь өөр өөр зорилготой байж болно (15). Тухайлбал Өөрөө өөртөө туслах бүлэг ядуурлыг бууруулах, хүнийг хөгжүүлэх, нийгмийг эрх мэдэлжүүлэх үр дүнтэй стратеги гэж үздэг (16). Тиймээс хөгжлийн салбарт жижиг зээлийн хөтөлбөр, орлого олох үйл ажиллагаанд анхаарлаа хандуулдаг. (Амьжиргаа бүрэлдэхүүн хэсгийг үзнэ үү)

Сүүлийн 20 жилд хөгжлийн бэрхшээлийн салбарт Өөрөө өөртөө туслах бүлгийг янз бүрийн хэлбэрээр ашиглаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн Өөрөө өөртөө туслах бүлгийг эрүүл мэндийн тусламж, сэргээн засалт, боловсрол, жижиг зээл, кампанит ажил гэх зэрэг төрөл бүрийн үйл ажиллагаанд хэрэглэж байна. Өөрөө өөртөө туслах бүлэг нь эрх мэдэлжүүлэхийг чиглүүлж чадна. Ямар нэгэн бүлэгт (эсвэл байгууллагад) хамаатай байх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамт олон дотроо оролцож чадах үндсэн аргуудын нэг нь юм (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага хэсгийг үзнэ үү). Бүлэгт хамрагдсанаар зохион байгуулах, үйл ажиллагаа явуулах, өөрчлөлт хийх талаарх мэдлэг болон чадвараа нэмэгдүүлж чадна (2).

Ихэнх ХОТСЗ-ын хөтөлбөр үндсэн эмчилгээ гэх мэт шууд тусламж хувь хүнд үзүүлж, хувь хүний түвшинд үйл ажиллагаагаа явуулдаг, мөн тэдгээр хөтөлбөрүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг өөрсдийнхөө асуудлыг шийдвэрлэх зорилгоор Өөрөө өөртөө туслах бүлэг байгуулахыг дэмждэг. Өөрөө өөртөө туслах бүлэг нь ХОТСЗ хандлагын матрицын нэг үндсэн элемент нь бөгөөд ХОТСЗ хандлагад шинээр гарч байгаа хамруулах зорилгод хүрэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс түүнийг эзэмших, хөгжлийн явцад оролцоог сайжруулах хэрэгслүүд болж болно (15). Энэ элемент нь голцуу ХОТСЗ-ын хөтөлбөр Өөрөө өөртөө туслах бүлгийг шинээр хэрхэн байгуулах, мөн ХОТСЗ-ын хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийн өмнө нь байгуулсан байсан Өөрөө өөртөө туслах бүлэгтэй болон бусад Өөрөө өөртөө туслах бүлэгтэй хэрхэн холбох тал дээр анхаарлаа хандуулсан буй.



Баянгол дүүргийн уналт таталттай хүмүүсийн Өөрөө өөртөө туслах бүлэг

Баянгол дүүргийн “Тэгш Дүүрэн” хороо, мэдрэлийн эмчтэйгээ хамтран “Уналт таталттай хүмүүс”-ийн дунд уулзалт, ярилцлага зохиов. Түүнээс хойш уналт таталттай хүмүүс сар болгон уулзалдаж, зовлон жаргалаа хуваалцаж нэгэн хамт олон болсон. Тэд унаж татсан хүнд анхан шатны тусламж хэрхэн үзүүлэх талаар суралцаж, мөн бэлэг дурсгалын зүйлс хийж сурч, олон нийтийн арга хэмжээнд оролцож байна. Мөн тэд төрсөн өдрөө хамтдаа тэмдэглэж, олон хүмүүстэй танилцаж, ирээдүйг харах итгэл өөдрөг болсон. Бүлгийн нэг гишүүн нь төрийн бус байгууллага байгуулан, олон нийтийн ажилд идэвхтэй оролцож, өөрийн дуу хоолойгоо хүргэж байна. Одоо энэ бүлэг 15 хүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд өөрсдийнхөө нийтлэг асуудлыг шийдэж, хувь хүнийхээ хүч чадлыг сайжруулж, амьдралын чанараа сайжруулахын тулд бүлэгт орох

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд шинээр Өөрөө өөртөө туслах бүлэг байгуулахад нь туслах, эсвэл байгаа бүлгүүдийг тогтвортой байлгахад нь туслах дэмжих үүрэгтэй.

Хүсч буй үр дүн

- Өөрөө өөртөө туслах бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд зориулагдаж орон нутгийн хамт олон дотор байна.
- Өөрөө өөртөө туслах бүлгийн гишүүд өөрсдийгөө гэр бүл, хамт олон дотроо хувь нэмэр оруулагч болгох мэдлэг, чадвартай болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд бусад хүмүүсийн элсэн ордог Өөрөө өөртөө туслах бүлэгт орох боломжтой байна.
- Өөрөө өөртөө туслах бүлэг нь ХОТСЗ-ын хөтөлбөрийг дэмждэг, тэдний гишүүд нь ХОТСЗ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төлөвлөхөд хамтарч оролцдог болно.
- Өөрөө өөртөө туслах бүлгүүд хамтарч холбоо байгуулж, өөртөө итгэлтэй хүмүүс болно.

Гол ойлголтууд

Өөрөө өөртөө туслах бүлэг

Онцлог шинж чанар

ХОТСЗ-ын хөтөлбөрийн Өөрөө өөртөө туслах бүлэгт зарим онцлог шинж чанарууд байдаг. Үүнд:

- Сайн дурын үндсэн дээр нэгдсэн – тэд өөрийн бүлгийн гишүүдийнхээ төлөө болон гишүүдээрээ үйл ажиллагаагаа явуулдаг, тогтмол уулздаг, шинээр гишүүн болох хүсэлтэй хүмүүст нээлттэй байдаг (17);
- Ихэнхдээ ямар нэгэн онцгой асуудлын төлөө байгуулагдсан байдаг, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол олох боломжгүй байна, орлого олох боломж хязгаарлагдмал байна гэх мэт;
- Бүлгийн гишүүдийн хэрэгцээнээс үүсч гарсан тодорхой зорилготой, түүнийг нь гишүүд бүгд мэддэг (15);
- Албан бус бүтэцтэй, гишүүд хэрхэн үр дүнтэй хамтарч ажиллахаа мэдэгдсэн үндсэн дүрэм, журам, удирдамжтай байдаг;
- Оролцооны аргаар ажилладаг – тусламж авах, мэдлэг, туршлагаа хуваалцах, туслах, бусдаас суралцах;
- Бүлгийн гишүүд хамтарч хариуцлагаа хүлээдэг – гишүүн бүр тодорхой үүрэгтэй, бүлэгтээ өөрийн нөөц бололцооноос хувь нэмэр оруулдаг;
- Шийдвэр гаргахад ардчилсан байдлаар гаргадаг;
- Бүлгийг байгуулахад шаардлагатай бол гаднаас чиглүүлэгч ашиглаж, гишүүд өөрсдөө удирдах (15);
- Яваандаа өргөн цар хүрээтэй асуудалд анхаарлаа хандуулах;
- Бүлгүүд нийлж, арай том газар нутгийг хамарч холбоо байгуулах боломжтой.

Жишээ 14 Гана

Өөрөө өөртөө туслах бүлгүүд амьжиргааг дэмждэг

Ганагийн зүүн бүсийн Аквапим өмнөд дүүргийн Кодобеда-д дөрвөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийнхөө эдийн засгийн нөхцөл байдлаа сайжруулах зорилгоор өөрөө өөртөө туслах бүлэг байгуулахаар шийджээ. Тосгоны өндөр настнууд болон манлайлагчтай уулзахад мал аж ахуй эрхлэхэд эхлэл болгож гурван эм ямаа өгөхийг хүсчээ. Тэдний хүсэлтийг зөвшөөрч бүлэг ажлаа эхлэв. Удалгүй ямаа төллөж, ишигнүүдийг нэг гишүүндээ өгч үржүүлүүлж, үндсэн ямаагаа бүлгийн эхний гишүүн маллаж үлдэв. Ямаа дахин төллөж, ишигнүүдийг тухайн гишүүн авч үлдэж, үндсэн ямаагаа зарж, мөнгөөр нь дахин ямаа худалдан авч дараагийн гишүүндээ өгөв. Энэ явц нь бүх гишүүд ямаагаа өсгөн үржүүлж, өөрсдөө хангалттай мөнгө олтлоо үргэлжилсэн.



Гишүүнчлэл

Бүлгийн гишүүд сайн дураараа ажилладаг буюу цалин авдаггүй гэхдээ тэд бие биедээ харилцан тусалж өөрсдийнхөө нөхцөл байдлыг өөрчлөхийн тулд тогтмол, системтэйгээр ажилладаг. ХОТСЗ-ын хөтөлбөрийн хүрээнд өөрөө өөртөө туслах бүлгүүд ихэнхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн хүмүүсийг хамруулдаг. Эдгээр бүлгүүд ихэнхдээ жижиг, цөөн хүнтэй, гэхдээ цаг хугацааны эрхэнд гишүүдийн тоо өсч, 7-30 гишүүнтэй болдог. Жижиг бүлгүүд ярилцлага болон шийдвэр гаргахад бүх гишүүдээ үр дүнтэй оролцуулж чаддаг, харин арай том хэмжээтэй бүлгүүд илүү хүчтэй, эрх мэдэлтэй, нөлөөтэй байдаг.

Чиглүүлэх ба манлайлал

ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтнууд өөрөө өөртөө туслах бүлэг шинээр үүсч байгаа тохиолдолд чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэх шаардлагатай байж болно. Сонгогдсон удирдагчыг бүлэгтээ дэндүү давуу эрхтэй байлгахгүйн тулд ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан удирдаж, чиглүүлж болно. Мөн тэд бүлгийн зарим нэг гишүүд ашгаас илүү ихээр хүртэхээс сэргийлж, бүлгийг урамшуулж, бүлгийн үйл ажиллагааны талаар сургалт зохион байгуулж болно (15). Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах хүн өөрөө хөгжлийн бэрхшээлтэй байх албагүй, гэхдээ ялгаварлан гадуурхалтын талаар туршлагатай байвал бүлэг болон гадны хүн хоёрын хоорондын ойлголт болон бусдын төлөө зовдог чанар нь бэхжинэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүн чиглүүлэгч хийвэл бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд үлгэр жишээ нь болж болно.

Жишээ 15 БНХАУ

Өөрөө өөртөө туслах бүлгийг дэмжих нь

Бүгд найрамдах Хятад ард улсын өөртөө засах Төвдийн ХОТСЗ-ын хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээнд хариу үзүүлэх шинэ аргыг олохын тулд эцэг, эхтэй нь ажиллаж байна. Өөрийнхөө хүүхдийг ялгаварлан гадуурхдаг, мухар сүжигтэй эцэх эхчүүд, хүүхдүүдээ сургуульд явуулахгүй байдаг эцэг эхчүүдийг сонгов. Тэд мөн хүүхдүүдээ хамт олон дотроо авч явах дургүй байв. Өөрөө өөртөө туслах бүлгийн тухай мэдээлэл өмнө нь авч байсан ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан тэдгээр эцэг эхчүүдэд өөрөө өөртөө туслах бүлэг тус болж болохыг анзаарч харжээ.

Хоёр эцэг, эх нийлж өөрөө өөртөө туслах бүлэг байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд ажлаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхээр эхлэв. Тэд энэхүү ажиллагаагаа орон нутгийн цайны газарт зохион байгуулав. Тэд бие биендээ итгээд ирэхээр туршлагаа хуваалцдаг болж, бүлэг нь хоёр гишүүнтэй байснаа 12 хүртэл нэмэгджээ. Хамт олон тэдэнд эерэг хандаж, хүмүүсийн хандлага аажим аажмаар өөрчлөгдөж, олон хүмүүс

тэдэнд янз бүрийн байдлаар тусалж эхлэв. Жишээ нь уулзалтын үеэр тэдэнд тэргэнцэр өгөв. Энэ нь маш их урам зоригийг өгөв. Олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд хамрагдаж эхэлж, гэр бүл нь хүүхдүүдээ хүлээн зөвшөөрч, мөн хамт олны ажилд хамруулдаг болов.

Өөрөө өөртөө туслах бүлэг нь ХОТСЗ-ын хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зарим нэг үйл ажиллагаанд аажмаар оролцдог болсон. Тэд хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ядуу айлд ашиг өгөх зорилгоор цайны газар байгуулав. ХОТСЗ-ын хөтөлбөр тэдэнд эхлэлийн дэмжлэг үзүүлж, бизнесийн сургалт зохион байгуулав. Мөн энэ бүлэг нь хүүхдийн сэргээн засалтын төлөвлөгөөг ажлын ачаалал болон боловсролын түвшнээс болоод хийхэд хүндрэлтэй байгаа айлуудад очиж туслалцаа үзүүлдэг. ХОТСЗ-ын хөтөлбөр өөрөө өөртөө туслах бүлгийн гишүүдэд хүүхдийн хөгжлийг дэмждэг сэргээн засалтын энгийн ажиллагаануудыг зааж өгч, ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан тэдэнтэй хамт айлаар орж, аажим аажмаар тэдний өөрөө өөртөө итгэх итгэл, чадварыг нь нэмэгдүүлж байна. Энэ бүлгийн амжилтыг бусад нь гайхан харж, бусдыг ижил төрлийн өөрөө өөртөө туслах бүлэг байгуулах хүслийг төрүүлсэн.



Өөрөө өөртөө туслах бүлэг байгуулахад тулгардаг бэрхшээлүүд

Хотын болон хөдөөгийн өөрөө өөртөө туслах бүлэг

Өөрөө өөртөө туслах бүлгийг хөдөө орон нутагт байгуулах нь илүү хялбар байдаг гэдэг нь ХОТСЗ-ын хөтөлбөрийн туршлагаас харагддаг. Өөрөө өөртөө туслах бүлгийг хотод байгуулахад зарим нэгэн тодорхой шалтгаанаас болоод хүндрэлтэй байдаг (15), тухайлбал: шилжилт хөдөлгөөн байнга давтагддаг, бие биедээ итгэхэд болон бүлгийн гишүүд бие биедээ хамаатай байхад бэрхшээлтэй гэх мэт. Хөдөө орон нутагт газар зүйн хувьд тусгаар амьдардаг, гишүүд бие биенээсээ хол амьдардаг, харилцаа холбоо хязгаарлагдмал зэрэг нь тэднийг байнга уулзахад хүндрэл учруулж болно.

Эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд

ХОТСЗ-ын хөтөлбөрийн туршлагаас харахад эмэгтэйчүүдийн бүлгийг байгуулахад эрэгтэйчүүдийнхээс илүү хялбар байдаг. Эмэгтэйчүүд бие биетэйгээ эвтэй байх тал дээрээ илүү хүчтэй байдаг учир хамтарч ажиллаж чаддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс нэг бүлэгт байхад эмэгтэйчүүд өөрийгөө төлөөлж дуугарах, тэдний үгийг сонсох, мөн тэдний асуудлыг харилцан ярилцаж байгаа эсэхийг баталгаажуулах нь чухал.

Боловсролын түвшин

Өөрөө өөртөө туслах бүлгийн гишүүдийн боловсролын түвшин харилцан адилгүй өөр байдаг. Ихэнхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын түвшин доогуур байдаг учраас тэдэнд сул тал илүү тохиолддог. Боловсрол өндөртэй хүмүүс нь бүлгийн уулзалтанд давуу эрх эдлэхгүй байх нь чухал бөгөөд жижиг зээл дээр түшиглэсэн өөрөө өөртөө бүлгийн хувьд ашгаа тэгш бус хуваарилахгүй байх нь чухал. Бүлэг дотор тэгш бус байдал үүсгэхгүйн тулд бүлэг байгуулах үедээ бие биетэйгээ нэгдэж, бичиг үсэг муутай эсвэл дуу хоолой нь бага гардаг хүмүүсээ чадавхжуулахад илүү цаг гаргах хэрэгтэй.

Нэг төрлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүлэг

Ихэнх тохиолдолд ижил хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эсвэл тэдний төлөө ажиллах бүлгийг байгуулдаг. Хэдийгээр нэг ижил хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүлгийн зорилго тодорхой байдаг боловч бага хүн амтай, ижил төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс цөөн газарт өөр өөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээр бүлэг байгуулах нь амьдралд илүү нийцтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бэрхшээлийн хэлбэрээсээ илүү тэдний үндсэн хэрэгцээ болох хоол хүнс, орон байр, эрүүл мэндийн тусламж, боловсрол гэх зэрэг нь ижил байдаг. Нэг хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн байгуулсан өөрөө өөртөө туслах бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хооронд нь хувааж, цөөн байгаа нөөц бололцоон дээр өрсөлдөөн бий болгоод байдаг.

Хараат байдал

Хөгжлийн бэрхшээл нь хараат байдалтай үргэлж холбоотой байдаг, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй аливаа зүйлийг хамтарч хийхээсээ илүү тэдний төлөө хийдэг. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс аливаа зүйлд хувь нэмэр оруулагч байхаасаа илүү хүлээн авагч байдаг төдийгүй тэд өөрөө өөртөө туслах бүлэг болон үйл ажиллагаануудад оролцох урам зориг муу, итгэлгүй байдаг.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

Өөрөө өөртөө туслах бүлэг шинээр байгуулахад дэмжлэг үзүүл

ХОТСЗ-ын хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн өөрөө өөртөө туслах бүлэг байгуулахад идэвхтэй үүрэг гүйцэтгэх ёстой. Өөрөө өөртөө туслах бүлэг байгуулах явц нь тухайн орон нутгийн нөхцөл байдал, бүлэг бүрт хэрэгтэй тусламж дэмжлэгийн түвшнээс хамаараад харилцан адилгүй байдаг. Дараах санал болгож байгаа үйл ажиллагаанууд нь ерөнхий саналууд юм. Үүнд:



Эхэл

ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдтэй гэрт нь ажиллаж хэрэгцээгээ тодорхойлж, хөгжлийн бэрхшээлийн талаар болон боломжтой тусламж дэмжлэгийн хэлбэрийн талаар үндсэн мэдээлэл олгох зэргээр ихэнхдээ ажиллаж эхэлдэг. Итгэл үнэмшил, өөртөө итгэлтэй байх байдал нь бэхжмэгц, тэднийг ижил бэрхшээлтэй, ижил туршлагатай бусадтайгаа уулзахыг дэмжих хэрэгтэй. Энэ шатанд ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан дараах зүйлийг хийж болно Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдэд өөрөө өөртөө туслах бүлгийн агуулгын талаар мэдээлэл олгох (бүлэгт хамрагдахын давуу тал, орлого олж гэр бүлээ тогтвортой байлгахын тулд бүлэг байгуулах гэх мэт), тэднийг бүлэг байгуулахыг дэмжих. Бүлэг тогтмол ажил, орлого олгож хүмүүст шууд хэрхэн туслах талаар мэдэхийг хүсч болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг нэгдэхийг сонирхож байгаа бусад хүмүүсийг олж, тэдэнтэй ярилцахыг санал болго.
- Хэрэв хүмүүсийн сонирхол, урам зориг байвал бүх хүмүүсийн очиж чадах газарт албан ёсны төлөвлөгөөт уулзалтыг зохион байгуул.

Төлөвлө

Бүлэг юун дээр анхаарлаа хандуулах талаар сэтгэгдлээ хуваалцаж, туршлагаа солилцож, ойлголт нэмэгдүүлж, мэдээлэл болон нөөц бололцоогоо солилцох замаар ярилц.

- Бүлгийн ашигт ямар нөөц бололцоогоор хувь нэмрээ оруулахыг хүсч байгаа талаар хүмүүсээс асуу.
- Бүлгийн ахлагч эсвэл зохицуулагчийг ол. Тэд нэгээс илүү байх нь чухал.
- Бүлгээ эзэмших, хариуцлагаа мэдэхэд нь тус болох үүднээс үүргийг нь аль болох эрт хуваарилж өг.
- Бүлэгтээ нэр өгч, бүлгийн таних тэмдгийг бий болго.
- Бүлэгт хэн нэгдэж орж болохыг шийдвэрлэ. Бүлгийг эхлээд жижиг хэмжээгээр байгуулж, дараа нь өөр хүмүүс нэгдэж ороход боломжтой байлга.
- Хэр ойрхон хугацаанд уулздаг байхаа мөн анхны уулзалтынхаа сар, өдрийг товлго. Уулзалт хүн бүрийн хүрч чадах газар (тэдний амьдарч байгаа газраас хол биш) зохион байгуулах хэрэгтэй. ХОТСЗ-ын хөтөлбөр болон бүлгийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байхуйц газар, тухайлбал сургууль дээр уулзалтыг зохион байгуул.

- Шаардлагатай бол хүмүүсийг эхний уулзалтанд ирүүлэхийн тулд бүлгийг хэрхэн нийтэд түгээхээ шийд. Үүнийг хийхдээ хүмүүстэй ярилцаж, орон нутгийн радио эсвэл сонин дээр сурталчилгаа, зурагт хуудас гэх мэтийг ашиглаж болно.

Уулзалт зохион байгуул

ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтан уулзалтыг бие дааж зохион байгуулж болохгүй, харин тэд өөрөө өөртөө туслах бүлгийн уулзалтын үндсэн бүтцийг мэдэж байх ёстой. Шаардлагатай тохиолдолд бүлэгт тусалж, дэмжинэ. Үндсэн бүтцэд:

- Уулзалтанд хүмүүсийг ирэхээр мэндлэх, найрсгаар урих
- Уулзалтыг нээх, гишүүд өөрсдийгөө танилцуулах
- Нууцыг сахих дүрэм боловсруулах – тухайлбал уулзалтан дээр юу болсон, юуны тухай ярьснаа нууцлах – нууцыг соёлын өөр өөр нөхцөл байдалд өөрөөр тайлбарладаг. Тиймээс бүлэг юуг нууцлахаа өөрсдөө шийдэх нь чухал.
- Уулзалтын гол үйл ажиллагааг зохиох
- Уулзалтын протоколыг хөтлөх, оролцогчдын яриаг ярилцлагын гол сэдэв, гаргасан шийдвэрийг тэмдэглэж авах
- Дараагийн уулзалтын он, сар, өдөр, цагийг товлон гэх мэт захиргааны ажлыг гүйцэтгэх
- Уулзалтыг хаах

Чиглүүл

ХОТСЗ-ын хөтөлбөр өөрөө өөртөө туслах бүлгүүдийг үр дүнтэй хамтран ажиллахад нь чиглүүлэх үүрэгтэй. Тухайлбал ХОТСЗ-ын хөтөлбөр дараах зүйлүүдийг хийж чадна. Үүнд:

- Ахлагчид хүссэн үед нь тусламж, дэмжлэг үзүүлэх
- Уулзалтуудыг зохион байгуулж эсэхийг баталгаажуулах. Тэгвэл бүх гишүүд юу болж байгаа талаар ойлголттой байж, мөн оролцох болно.
- Үүрэг, хариуцлагыг бүлэг дотроо ротацийн (тойрч) маягаар шилжүүлэхийг нь дэмжих
- Бүлэг бие биендээ хэрхэн харилцан дэмжлэг үзүүлэхэд туслах, тухайлбал нөхөрлөх, хүүхдүүдээ сургуульд хүргэж өгөх, хадгаламжийн үйл ажиллагаа эхлэх гэх мэт
- Бүлгийн үйл ажиллагааны ашгийг ил тод, шударга хуваалцаж байгаа эсэхийг шалгах
- Бүлэг сайн тогтвортой болмогц бүлгийн дүрмийг боловсруулахад туслах
- Санхүүгийн дэмжлэг үзүүлэх, тухайлбал өөрөө өөртөө туслах бүлгийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд буцалтгүй тусламж олгох, мөн банкинд данс нээхэд нь туслах гэх мэт

Чадавх бэхжүүл

Бүлгүүд үйл ажиллагаагаа бие дааж, үр дүнтэй явуулахаас өмнө тэдний чадавхийг бэхжүүлэхэд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Бүлгийн гишүүдийн мэдэж байх чухал чадвар нь ажлын төлөвлөгөө гаргах, уулзалтуудыг удирдах, олон нийтийн өмнө итгэлтэйгээр ярих, протокол хөтлөх, зөрчилдөөнийг шийдвэрлэх, асуудлыг шийдэх, ардчилсан байдлаар шийдвэрээ гаргах, мониторинг хийх гэх мэт. Заримдаа өөрөө өөртөө туслах бүлгүүд зарим нэг

тодорхой чадвараа хөгжүүлдэг, заримдаа дээрх чадварууд бүлэг дотор байдаг. Өөрөө өөртөө туслах бүлгийн уулзалтууд нь тэднийг шинэ чадвар эзэмшихэд сайхан боломжийг олгодог.


Шинээр байгуулагдсан өөрөө өөртөө туслах бүлгүүд өмнө нь байгуулагдсан бүлгүүдээс туршлага судалж, сурдаг. Шинээр байгуулагдсан бүлгүүд өмнө нь байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа бүлгүүдээс урьж ярилцаж, түүнээсээ ашиг хүртэж болно. Шинээр байгуулагдсан өөрөө өөртөө туслах бүлэг хүмүүсээс хамгийн их туршлагыг сонсож авдаг хүмүүс юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрөө өөртөө туслах бүлгүүд хоорондоо холбоо тогтоох нь бие биенээсээ сурах, цаашдаа холбоотой байх, харилцан туслалцах зэрэг ашгийг хүртдэг.

Эхэн үедээ бүлгүүд өөрийнхөө үйл ажиллагаанд нийгмийн эсвэл улс төрийн үйл ажиллагааг оруулахдаа шийдвэртэй бус байдаг. Учир нь тэд чадвар эсвэл ноухауг нь сайн мэдэхгүй гэж боддог. Гэхдээ цаг хугацаа өнгөрөх тусам, тэвчээртэй, урам зоригтой байвал бүлгийн гишүүд өөрсдийнхөө нөхцөл байдлыг өөрчлөхөд шаардлагатай үйл ажиллагааг ойлгох, төлөвлөх, хэрэгжүүлэх зэрэг чадвараа нээнэ. Тухайлбал бүлэг орон нутгийн засаг захиргаандаа ундны усыг аюулгүй болгож, ариун цэврийг сайжруулах өргөдөл өгч болох юм.

Жишээ 16 Бүгд найрамдах Доминикан улс

Ээж нарын өөрөө өөртөө туслах бүлэг хүүхдүүдийн амьдралыг сайжруулж байна

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ээж нарын өөрөө өөртөө туслах бүлэг Бүгд Найрамдах Доминикан улсын Сантиаго хотын слам /удам дамжсан ядуу хүмүүсийн дүүрэг/ дүүрэгт нэгэн олон улсын төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулагдав. Бүлгийн гишүүдийн нийтлэг сонирхол нь хүүхдүүдээ үйлчилгээнд хамруулах байв. Засгийн газар тэдний хүүхдүүдийн эрүүл мэнд, боловсролд ямар нэгэн зүйл хийхгүй байв. Засгийн газрын тусламж дэмжлэг байхгүй учир ээж нар сэргээн засалтын үйлчилгээ болон боловсрол олгох ажлыг өөрсдөө хийхээр шийдэв. Тэд олон улсын төрийн бус байгууллагаас сургалт авч, Сантиаго хотын слам дүүргийн бусад хүүхдүүдийг үйлчилгээнд хамруулахаар үйл ажиллагаагаа өргөтгөв. Ээж нарын бүлэг өсөн дэвжсээр хөгжлийн бэрхшээлтэй өсвөр насны хүүхдүүдэд үйлчилгээгээ хүргэж, мөн зээлийн эргэлтийн сантай болов. Ээжүүд Засгийн газрын Хамтын ажиллагааны институтээс зээлийн эргэлтийн санг байгуулах, удирдах талаар туслах мэргэжилтнийг хайв. Ээжүүдийн бүлэг ийнхүү үйл ажиллагаагаа өргөжүүлж, хэрэгцээтэй салбараа нээж, нийгмийн үйл явдал, ойлголт нэмэгдүүлэх боломжууд, орлого олох гэх мэт олон ажлыг зохион байгуулж байна. Ээж нар өөрсдийнхөө амжилтыг бахархан харж, мөн хүүхдүүдийнхээ амжилтаар бахархаж байна.



Одоо ажиллаж байгаа өөрөө өөртөө туслах бүлгүүдийн дунд түншлэл байгуул

Олон газарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн өөр өөртөө туслах бүлгүүд байдаг ба тэд ХОТСЗ-ын хөтөлбөрөөс ангид бие дааж үйл ажиллагаагаа явуулдаг. Тэдгээр бүлгүүд нь хараагүй, эсвэл сонсголгүй, уяман өвчтэй, эсвэл газрын минэнд өртөгсдийн гэх мэтийн тусгайлсан бэрхшээлтэй хүмүүст үйлчилдэг байж болно. Зарим бүлгүүд нь хөгжлийн бэрхшээлийн эрх, орлого олох, эмэгтэйчүүд гэх мэтийн тусгай сэдвээр үйл ажиллагаагаа явуулдаг байж болно. “Өөрөө өөртөө туслах бүлэг” гэдэн нэр томъёоны оронд орон нутгийн хөгжлийн бэрхшээлийн бүлэг, эцэг эхийн бүлэг, нийгмийн бүлэг, ижил бэрхшээлтэй үе тэнгийн хүмүүсийн бүлэг, клуб, эсвэл харилцан туслалцах бүлэг гэх мэтээр нэрлэдэг байж болно.

Тэдгээр бүлгүүд болон ХОТСЗ-ын хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан өөрөө өөртөө туслах бүлгүүдийн зорилго нь адилхан байдаг. Тиймээс ХОТСЗ-ын хөтөлбөр тухайн хамт олон дотор байгаа ямар ч бүлгүүдтэй холбоо тогтоож, олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд хүрэхийн тулд мэдлэг, нөөц бололцоогоо хуваалцах түншлэлийг бий болгохын төлөө ажиллах чухал.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусад өөрөө өөртөө туслах бүлэгт орохыг дэмж

Өөрөө өөртөө туслах бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг онцгойлон хамруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг боловч ХОТСЗ-ын хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийг бусад бүлгүүдэд, тухайлбал эмэгтэйчүүдийн бүлэг, залуучуудын бүлэг, жижиг зээлийн бүлэг, фермерийн бүлэг гэх мэтийн бүлгүүдэд орохыг нь дэмжих хэрэгтэй. Дараах үйл ажиллагаануудыг санал болгож байна. Үүнд:

- Өөрөө өөртөө туслах бүлгүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулж, өөрийнхөө бүлгийн ижил эрхтэй гишүүн болгохыг дэмж. Тухайлбал бүлэг бүх хүмүүс орох боломжтой, дэд бүтцийг хангасан газарт уулзах
- Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүмүүст тулгарч байгаа нийтлэг асуудлыг тодорхойлох, тухайлбал эмэгтэйчүүдийн бүлэгт хүйсийн ялгавартай байдлын талаар ярилцлага өрнүүлэх. Бүх эмэгтэйчүүд энэ асуудалд хэрхэн хандахаа ярьж хуваалцах – өөрөө өөртөө туслах бүх бүлгийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрөө өөртөө туслах бүлгүүдтэй хамтарч эвсэл байгуулах эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүлэгтээ нэгтэн оруулахад урамшуулал олгож болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл тэдний гэр бүлийн гишүүн гольдролоороо явж байгаа өөрөө өөртөө туслах бүлгийг олж, тэдэнд тулгардаг бэрхшээлийн талаар ярьж, хөгжлийн бэрхшээлийг өөрөө өөртөө туслах бүлгийн ярилцлагын төлөвлөгөөнд оруулахыг нь дэмжих
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг өөр бусад гольдролоороо явж байгаа өөрөө өөртөө туслах бүлгүүдтэй холбохоосоо өмнө тэдэнд тохирох мэдлэг чадвар байгаа эсэхийг баталгаажуул. Тэгэхгүй бол тэднийг ялгаварлан гадуурхаж болно.

Өөрөө өөртөө туслах бүлгийн гишүүдийг ХОТСЗ-ын хөтөлбөрт оролцохыг нь дэмж

Өөрөө өөртөө туслах бүлгийн гишүүд (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгайлсан болон гольдролоороо явж байгаа өөрөө өөртөө туслах бүлэг) нь ХОТСЗ-ын хөтөлбөрийн хувьд чухал нөөц бололцоо нь мөн бөгөөд тэдэнд

ХОТСЗ-ын хандлагын талаар сайтар мэдээлэл олгох хэрэгтэй. Өөрөө өөртөө туслах бүлгүүд нь хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд, хамруулан хөгжүүлэх хандлагыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Өөрөө өөртөө туслах бүлгүүд нь мөн ХОТСЗ-ын хөтөлбөрийн үйл ажиллагаанд өөрийнхөө цагийг сайн дураараа зориулж, хувь нэмрээ оруулах (тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илрүүлэх, хүмүүст сэргээн засалтанд нь туслах, явцыг нь хянах гэх мэт) чадвартай байдаг. Хөгжлийн бэрхшээлээр дагнасан өөрөө өөртөө туслах бүлгүүд нь ХОТСЗ-ын хөтөлбөрт аажим аажмаар илүү том хэмжээний үүрэг гүйцэтгэх ёстой. ХОТСЗ-ын хөтөлбөрийн менежмент (төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах)-д оролцох нь хөтөлбөрийг илүү тогтвортой, нийтэд ил тод, тохиромжтой болгож чадна.



Өөрөө өөртөө туслах бүлгүүдийг хамтарч, нэгдэхийг нь дэмж

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн өөрөө өөртөө туслах бүлгүүд орон нутгийн түвшинд өөрчлөлт, ялгааг гаргаж чадах хэдий ч гишүүдийн чадвар илүү дээд түвшинд өөрчлөлт хийхэд чадвар нь хязгаарлагдмал байж болно. Олон хүмүүс нийлж өөрчлөлт хийж чаддаг. Тиймээс дараагийн шат бол өөрөө өөртөө туслах бүлгүүдийг (ХОТСЗ-ын хөтөлбөрөөр эхэлсэн болон бие дааж үйл ажиллагаагаа явуулдаг бүлгүүдийн аль аль нь) нэг “шүхэр” дор нэгдэхийг – үүнийг ихэнхдээ холбоо гэж нэрлэдэг - дэмжих явдал юм. ХОТСЗ-ын хөтөлбөр өөрөө өөртөө туслах бүлгүүдээс нэгээс хоёр гишүүнийг сонгож өөрөө өөртөө туслах бүлгийн холбоо байгуулахад чиглүүлж болно. Өөрөө өөртөө туслах бүлгийн холбоонд бүх бүлгийн, ижил тэгш эрхтэй хүмүүс (нас, хөгжлийн бэрхшээл, хүйс, нийгэм эдийн засгийн байдал)-ийг хамруулсан байх ёстой. Өөрөө өөртөө туслах бүлгийн холбооны үүрэг хариуцлага том бөгөөд энэ нь нэг өдөр өөрийнхөө эрхийг хамгаалдаг албан ёсны байгууллага болж болно.

Жишээ 17 Бангладеш

Тооны хувьд хүчтэй болох нь

Азгар Бангладешийелгачи хэмээх өөрөө өөртөө туслах бүлгийн анхны гишүүнээр элсэн орсон юм. Түүний ажилч хичээнгүй зан, хүсэл тэмүүлэл нь бүлгийнхээ даргаар сонгогдоход хүргэсэн. Өнөөдөр энэ бүлэг 21 гишүүнтэй, долоо хоног бүр уулзаж, тулгарч буй асуудал, холбогдох шийдвэрийн талаар ярилцдаг болсон. Азгар хөдөлгөөний бэрхшээлтэй бөгөөд газаргүй нь гэр бүлээ тэжээхэд асар том бэрхшээл байлаа. Тэр сардаа 10-12 өдөр л ажилладаг байв. Тэрээр Засгийн газраас хогийн цэгийн ойрхон газар авах зөвшөөрөл хүслээ. Түүний өргөдлийг зарим нэгэн тосгоны хүмүүс эсэргүүцэж байсан ч өөрөө өөртөө туслах бүлэг түүнийг дэмжсээр байжээ. Азгарт нэг акр газар олгож, төрийн бус байгууллага хөдөө аж ахуйн арга зүйн сургалтанд хамруулав. Азгар ногоо тарьж, түүнийгээ зарж, гэр бүлээ амьдралын энгийн түвшинд авч ирж чадав. Азгар өөрөө өөртөө туслах бүлгийн Порадха холбооны сонгуульд оролцож, дэд даргаар нь сонгогдов. Тэр Засгийн газраас хогийн цэгийн багахан газрыг холбоонд өгөхийг хүсч, гишүүдээр хулс түүлгэж уулзалтын байр бариулав. Түүний дараагийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олон хүлээж авахыг баталгаажуулах юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага

Танилцуулга

Дэлхий дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс засгийн газар болон нийгмийн бүх салбаруудын шийдвэр гаргагч нарт нөлөөлж, өөрсдийнхөө эрхийн төлөө өмгөөлөл хийхийн тулд байгууллага болж нэгддэг. Ийм байгууллагыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага гэж нэрлэдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмд тэгш оролцоход нь саад болж байгаа нийгмийн саад бэрхшээлд хариу үзүүлж, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусад хүмүүс хянахын эсрэг хариу үйлдэл үзүүлэх зэргээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд ажилладаг. Олон жилийн туршид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай эрүүл мэндийн мэргэжилтнүүд, гэр бүл болон бусад хүмүүс тэдний хэрэгцээ, нэн тэргүүний асуудал, эсвэл сонголтыг үл харгалзан ярьсан билээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрөө өөрсдийнхөө хэрэгцээ, хүсэл тэмүүлээ хэнээс ч илүү мэддэг хүмүүс юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд ихэнх хотод үндэсний болон бүсийн түвшинд байдаг. Ихэнх нь “нэг төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн” байгууллага буюу онцгойлсон нэг төрлийн бэрхшээлтэй, тухайлбал сонсгол, эсвэл харааны бэрхшээл (Дэлхийн хараагүй хүмүүсийн холбооны салбар гэх мэт)-тэй хүмүүсийг төлөөлсөн байгууллагууд байдаг, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүсийг хамруулсан “холимог хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн” байгууллага (тухайлбал Мауританийн Хөдөлгөөний болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн үндэсний холбоо) байж болно. Мөн олон оронд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын сүлжээ байдаг, тухайлбал Бурундигийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбоо. Мөн олон улсын түвшинд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд байдаг, тухайлбал Дүлий хүмүүсийн дэлхийн холбоо, Хараагүй хүмүүсийн дэлхийн холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын байгууллага гэх мэт. Эдгээр байгууллагуудын ихэнх нь Олон улсын хөгжлийн бэрхшээлийн эвсэл (IDA) зэрэг олон улсын сүлжээнд нэгдсэн байдаг.

Түүхээс харвал ХОТСЗ-ын хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай ойр дотно хамтарч ажиллаж байгаагүй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд ХОТСЗ-ын хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллаж байгаагүй олон шалтгаан байж болох юм. Өмнө нь ихэнх ХОТСЗ-ын хөтөлбөрүүд хөгжлийн бэрхшээлийн эмнэлгийн загвар дээр түшиглэсэн, хөгжлийн бэрхшээлгүй хүмүүс, мэргэжилтнүүд хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг идэвхтэй оролцуулж байгаагүйгээс үүдэлтэй байж болох юм. Мөн олон ХОТСЗ-ын хөтөлбөрүүд зарим нэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулж чадахгүй байсан. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын ихэнх нь нэн тэргүүнийхээ зорилт болгодог харааны эсвэл сонсголын бэрхшээлтэй хүмүүсийг хамруулж чадаагүй байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага, ХОТСЗ-ын хөтөлбөрүүдийн гарал үүсэл нь өөр боловч тэдний аль аль нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгож, нийгэмшүүлэх зэрэг ижил зорилго бүхий стратегитэй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд болон ХОТСЗ-ын хөтөлбөрүүд бие биенээ хүндэтгэж, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг хэрэгжүүлэх нэгдсэн зорилготой, амжилттай түншилж хамтран ажиллах нь маш чухал.

Жинхэнэ баатар

Ладак бол далайн түвшнээс маш өндөрт, хүнд нөхцөлд байдаг, жижиг хот, тосгонд хүмүүс нь амьдардаг Энэтхэгийн хойд хэсэгт байрлах Гималайн бүс юм. Тэнд хүн бүрийн тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрал хүнд. Хөгжлийн санаачилгууд тэрхүү бүсэд шинэ биш хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн хөтөлбөрүүдэд 2000 он хүртэл хамруулдаггүй байсан. 2000 онд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Намгял институт нэртэй төрийн бус байгууллага байгуулагдсан юм. Энэхүү төрийн бус байгууллага гол анхаарлаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангахын тулд тэднийг хөгжлийн хөтөлбөрүүдэд хамруулахыг баталгаажуулахад хандуулсан.

Ладакт болсон олон өөрчлөлтүүдийн түрүүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орж эхэлсэн. Тэдний нэг нь 2006 онд Ладакт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгуулсан “Хамруулалт ба эрхийн төлөөх ард түмний үйл ажиллагаа” байгууллагын (PAGIR) ерөнхийлөгч Мухамед Икбал юм. Икбал амьдралынхаа 30 жилийг ямар ч идэвхгүй, гэртээ орон дээрээ хэвтэж, хөгжим сонсож, найзуудтайгаа ярьж өнгөрөөсөн. Гэхдээ тэрээр 45 насандаа (2008) амжилттай бизнесмен болж, PAGIR байгууллагын ерөнхийлөгч болсон. Тэрээр “ядуу хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэг дүр зурагнаас өөрийнхөө орчныг хянадаг хүн болж өөрчлөгдсөн нэгэн юм. Икбал болон тэдний лобби бүлэг болох “Хамруулалт ба эрхийн төлөөх ард түмний үйл ажиллагаа” (PAGIR) нь Ладакт долоон жилийн хугацааны хамт олны хөгжлийн явцын эерэг үр дүн юм.

PAGIR-ын гол төслүүдийн нэг нь 200 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн орлого олох боломжийг олгосон хог хаягдал цуглуулах хөтөлбөр юм. Мухамед Икбал хэлэхдээ “Бидний Ладакт хэрэгжүүлж байгаа “Жунгва Шунгскёб” хог хаягдал цуглуулах хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор эхэлсэн бөгөөд одоо том асуудал болсон хог хаягдлыг шийдвэрлэхэд гар бие оролцож байна. Бид хог хаягдлыг их хэмжээгээр цуглуулж, дахин ашиглаж, дахин боловсруулалтанд оруулж, орчин тойрныг цэвэрхэн болгож байна. Энэ асуудлыг бүхэлд нь шийдэхэд бидний өмнө урт зам байгаа ч гэсэн бид ямар ч байсан эхлэлийг тавьсан... хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хог хаягдлыг цуглуулахад тэргүүлж, олон тооны хүмүүсийг ажил хөдөлмөртэй болгож байна” гэжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Намгял институт, DDRC, PAGIR байгууллагууд Ладак бүсэд ажлаа үргэлжлүүлсээр л байна. Одоо PAGIR хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг зохион байгуулж, тэднийг эрх мэдэлжүүлж, орлого олох ажиллагаа явуулж ядуурлаас гарахад тэднийг чадавхжуулах зэрэг

үйл ажиллагааг зохион байгуулахад тэргүүлэх байгууллага болсон. 2010 оны 3 сарын 20-нд Мумбайд PAGIR-ын хамруулсан нийгэм байгуулахад оруулж буй хувь нэмрийг үнэлж CNN-IBN Мухамед Икбалыг “Жинхэнэ баатар” шагналаар шагнасан юм.



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг хэрэгжүүлэхэд болон хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэхэд ХОТСЗ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд хамтарч ажиллах.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага байгаа бол тэдэнтэй хамтарч ажиллах, хэрэв байхгүй бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага байгуулахад шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх явдал юм.

Хүсч буй үр дүн

- ХОТСЗ-ын хөтөлбөр болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд одоо байгаа ХОТСЗ-ын хөтөлбөр, эсвэл шинээр эхэлж буй ХОТСЗ-ын хөтөлбөрийг төлөвлөж, хэрэгжүүлж, хяналт тавихад хамтарч ажилладаг болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд ХОТСЗ-ын хөтөлбөрийг илүү олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулдаг болоход нь дэмжлэг үзүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд ХОТСЗ-ын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхийг дэмжинэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг хамт олны/орон нутгийн түвшинд шинээр байгуулж, тэднийг бүсийн болон/эсвэл үндэсний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд холбох хэрэгтэй.

Гол ойлголтууд

Өөрөө өөртөө туслах бүлэг

Онцлог шинж чанар

ХОТСЗ-ын хөтөлбөрийн Өөрөө өөртөө туслах бүлэгт зарим онцлог шинж чанарууд байдаг. Үүнд:

- Сайн дурын үндсэн дээр нэгдсэн – тэд өөрийн бүлгийн гишүүдийнхээ төлөө болон гишүүдээрээ үйл ажиллагаагаа явуулдаг, тогтмол уулздаг, шинээр гишүүн болох хүсэлтэй хүмүүст нээлттэй байдаг (17);
- Ихэнхдээ ямар нэгэн онцгой асуудлын төлөө байгуулагдсан байдаг, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол олох боломжгүй байна, орлого олох боломж хязгаарлагдмал байна гэх мэт;
- Бүлгийн гишүүдийн хэрэгцээнээс үүсч гарсан тодорхой зорилготой, түүнийг нь гишүүд бүгд мэддэг (15);
- Албан бус бүтэцтэй, гишүүд хэрхэн үр дүнтэй хамтарч ажиллахаа мэдэгдсэн үндсэн дүрэм, журам, удирдамжтай байдаг;
- Оролцооны аргаар ажилладаг – тусламж авах, мэдлэг, туршлагаа хуваалцах, туслах, бусдаас суралцах;

- Бүлгийн гишүүд хамтарч хариуцлагаа хүлээдэг – гишүүн бүр тодорхой үүрэгтэй, бүлэгтээ өөрийн нөөц бололцооноос хувь нэмэр оруулдаг;
- Шийдвэр гаргахад ардчилсан байдлаар гаргадаг;
- Бүлгийг байгуулахад шаардлагатай бол гаднаас чиглүүлэгч ашиглаж, гишүүд өөрсдөө удирдах (15);
- Яваандаа өргөн цар хүрээтэй асуудалд анхаарлаа хандуулах;
- Бүлгүүд нийлж, арай том газар нутгийг хамарч холбоо байгуулах боломжтой.

Гишүүнчлэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд “Бидэнгүйгээр бидний тухай юу ч байхгүй” гэдэг уриаг дэмждэг. Тэд бол “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн”, “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө”, “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдөө удирддаг” байгууллага юм. Тиймээс удирдах зөвлөл болон гишүүнчлэлийн түвшинг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх нь хянадаг байгууллага байдаг. “Нэг төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага” тухайн бэрхшээлтэй хүмүүсийн гишүүнчлэлээр хязгаарладаг (тухайлбал Хараагүй иргэдийн байгууллага бол нэг төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага) бол “олон төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй” байгууллагын гишүүнчлэл илүү өргөн хүрээг хамардаг (тухайлбал сонсгол, хараа, хөдөлгөөн, болон сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүсийг бүгдийг нь хамруулсан байгууллага).

Хэрэгцээ, агуулга, боломжоос шалтгаалж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын хэлбэр, цар хүрээ өөр өөр байж болно. Сонсголгүй хүмүүс бусад байгууллагатай хамтрахаасаа илүү өөрсдийнхөө байгууллагыг байгуулахыг эрхэмлэдэг. Оюуны бэрхшээлтэй хүмүүс “олон төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй” байгууллагад орохоор дуу хоолойгоо гаргаж, санаа бодлоо илэрхийлэхдээ дутмаг байж болно. Тиймээс өөрсдийн адвокати бүлгээ байгуулахыг эрхэмлэдэг ба заримдаа хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсийн тохирох дэмжлэг хэрэгтэй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага ямар ч хэлбэртэй бай, хамгийн гол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс төлөвлөгөөгөө хамтран зохион байгуулахад оролцох нь чухал бөгөөд бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийнхээ өөр өөр байдлыг хүндэтгэн үзэж байх нь чухал (тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, өндөр настай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолойг сонсох хэрэгтэй).

Өөрөө өөртөө туслах бүлгүүд ба Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд

Өөрөө өөртөө туслах бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын онцлог шинж нь орон бүрт харилцан адилгүй, заримдаа энэ хоёрыг ялгаж салгахад хэцүү ч байж болно. Тухайлбал олон оронд өөрөө өөртөө туслах бүлгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага гэж хардаг, ялангуяа тэд хамтарч шүхэр байгууллагаа байгуулсан бол. Энэхүү ХОТСЗ-ын хандлагын Удирдамжид тодорхойлсноор өөрөө өөртөө туслах бүлэг бол орон нутгийн түвшинд байгуулагдсан, албан бусаар үйл ажиллагаа явуулдаг, зөвхөн өөрсдийнхөө гишүүдийн хэрэгцээнд анхаарлаа хандуулдаг бүлэг гэнэ. Гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлгүй, тухайлбал гэр бүлийн гишүүн байж болно. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага бол албан ёсны бүтэцтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө хяналт тавьдаг байгууллага юм. Тэд хүний эрхийн талаар адвокати хийж, бодлого болон нөөцийн хуваарилалтанд нөлөөлөх зэрэг илүү өргөн цар хүрээтэй ажилладаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд ба ХОТСЗ-ын хөтөлбөрүүдийн хоорондын түншлэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний болон олон улсын байгууллагууд НҮБ-ын байгууллагууд, Гишүүн орнууд болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө утга төгөлдөр үйл ажиллагаа явуулж, хөтөлбөр хэрэгжүүлж байж хэрэгждэггүй эрхийг хүчин төгөлдөр болгож, бэхжүүлж чадна. Одоогийн байдлаар бага орлоготой орны олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хотын ядуу хэсэгт болон хөдөө орон нутагт/алслагдсан газарт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс Конвенциос ашиг хүртэж чадахгүй байна. Энэхүү ХОТСЗ-ын хандлагын Удирдамжийн цохон тэмдэглэж байгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэгш үйлчилгээ, боломжийг хүртэхийн тулд ХОТСЗ-ын хөтөлбөр хамт олонд түшиглэсэн хамруулан хөгжүүлэх хандлагад онцгойлон анхаарал тавих хэрэгтэй – ХОТСЗ хандлага бол Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг хамт олны түвшинд хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах стратеги/хэрэгсэл юм. Өмнө нь ХОТСЗ хандлага дээрээс доошоо чиглэлтэй хэрэгждэг байсан бол шинэ хандлагаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо нь ХОТСЗ-ын хөтөлбөрийг амжилттай хэрэгжихийн амин чухал зүйл юм. Түүхээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн асуудал гэж анхаарч хардаг байсан бол одоо тэд хөгжлийн бэрхшээлийн хөгжлийн асуудал гэж таньж хардаг болсон. Үнэндээ олон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд Хятад, Энэтхэг, Малауи, Непал зэрэг оронд ХОТСЗ-ын хөтөлбөрийг эхэлсэн байдаг. Эдгээр хөгжил нь ХОТСЗ-ын хөтөлбөр болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын хоорондын хүчтэй, үр нөлөөтэй түншлэлийн шинэ боломжийг олгож байна.

Бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд, хамт олонд хүрэх мэдлэг, чадвар, нөөц бололцоог баталгаажуулахад ХОТСЗ-ын хөтөлбөр болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд хамтарч ажиллаж болно. Ингэж байж ХОТСЗ-ын хөтөлбөр “Бидэнгүйгээр бидний тухай юу ч байхгүй” уриаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулсан хамт олон болгоход хамтран ажиллаж буй бүх оролцогч гол хүмүүст санал болгож чадна. Түншилснээр ХОТСЗ-ын хөтөлбөр болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд аль аль нь урт удаан хугацаанд тогтвортой, үр нөлөөтэй ажиллаж чадна.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтарч ажилла

ХОТСЗ-ын хөтөлбөр болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд ижил зорилготой, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүд ашиг хүртэхэд шаардлагатай мэдлэг, туршлага, нөөц бололцоо аль алинд нь бий. ХОТСЗ-ын хандлагын энэхүү Удирдамжийн бусад хэсгүүдэд хамтран дараах үйл ажиллагаануудыг явуулж болох юм. Үүнд:

- ХОТСЗ-ын хөтөлбөр нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг ХОТСЗ-ын хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, мониторинг хийхэд оролцуулах, “Бидэнгүйгээр бидний тухай юу ч байхгүй” агуулгыг хүндэтгэх;
- Засгийн газрын ажилтнууд орон нутгийн манлайлагч нар болон эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, нийгмийн салбарын үйлчилгээ үзүүлэгч нарт ХОТСЗ-ын хандлагын сургалт явуулахдаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын төлөөлөл болон гишүүдийг ашиглах;

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтнууд болон өөрөө өөртөө туслах бүлгийн гишүүдэд бодлого, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, өмгөөллийн үйл ажиллагаа явуулахын ашиг тус ба хэрэгцээний талаар сургалт явуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд зориулсан сургалтын материал болон хамт олны нөөцийн жагсаалтыг боловсруулахад хамтран ажиллах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх мэдэлжүүлэхэд хамтран ажиллах;

ХОТСЗ-ын хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын гишүүдийг оролцуулахыг баталгаажуул

Хамт олонд түшиглэн сэргээн засах гэдэг нэр томьёо нь хамт олныг ХОТСЗ-ын хөтөлбөрт гол үүрэг гүйцэтгэхийг санал болгодог билээ. “Хамт олон”-ыг нийгмийн ямар нэгэн хэлбэрийн зохион байгуулалт болон холбоо нэгдэлд хамтдаа амьдарч буй хүмүүс гэж тодорхойлж болох юм. Гэхдээ ерөнхий хамт олон нэгэн төрлийн байдаг бол харин гишүүд нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын онцлог байдал, сонирхол, хүсэл тэмүүллийн хувьд өөр өөр байдаг (12). Тухайлбал: “уламжлалт” хөдөөгийн хамт олон, гишүүд нь өөр өөр үндэстэн ястаны бүлэгт хамаарагддаг бөгөөд тэд өөр хэлээр ярьж, өөр шашин шүтэж, өөр соёлтой байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагыг ХОТСЗ-ын хөтөлбөрийг дэмжих стратегиа болгохыг нь дэмж

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага ХОТСЗ-ын хөтөлбөрт дараах байдлаар дэмжлэг үзүүлж болно. Үүнд:

- ХОТСЗ хандлагыг үндэсний болон олон улсын түвшинд хөгжилд хүрэх стратеги гэж дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенци болон Мянганы хөгжлийн зорилтоор дамжуулж хөгжлийн бэрхшээлтэй олон хүмүүст хүрэхийг баталгаажуулах;
- ХОТСЗ хандлагын стратегийг засгийн газрын бодлого, хөтөлбөрт оруулах, түүнд шаардлагатай төсөв тавихыг лоббидох;
- Хамт олонд хөгжлийн бэрхшээл болон ХОТСЗ хандлагын талаар ойлголт өгч, тэднийг ХОТСЗ-ын хөтөлбөрийн бүх үйл ажиллагаанд оролцохыг дэмжих;
- Хот, хөдөө, ядуу хороололд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрөө өөртөө туслах бүлэг байгуулахыг нь дэмжиж, тэдгээр өөрөө өөртөө туслах бүлгүүдийг хамт олны түвшинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага болоход нь чадавхийг бэхжүүлэх;
- ХОТСЗ хандлагын матриц ашиглан ХОТСЗ-ын хөтөлбөрийг шууд хэрэгжүүлэх;

Хамт олонд түшиглэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага байгуулахыг дэмж

Олон оронд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд том хотуудад байдаг ба Бангладеш, Эл Сальвадор, Өмнөд Африк, Уганда зэргийг эс тооцвол орон нутагтаа салбар, төлөөлөлгүй байдаг. Харин ХОТСЗ-ын хөтөлбөрийн давуу тал нь тэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй шууд газар дээр нь харилцдаг учраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага байгуулах сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусалж чадна. Хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага байгуулж, түүнийг удирдах ёстой. Гэхдээ ХОТСЗ-ын хөтөлбөрийн ажилтнууд дараах чухал үүргийг гүйцэтгэж болно. Үүнд:

- Өөрийнхөө байгууллагыг байгуулахыг хүсч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олж, илрүүлэх. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хүүхэд болон бусад бүх хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс (ялангуяа хүнд хэлбэрийн эсвэл хавсарсан бэрхшээлтэй хүмүүс), болон өөр өөр нийгэм эдийн засгийн бүлэг хүмүүсийн төлөөлөл орсон гэдгийг баталгаажуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага байгуулахын ач холбогдлын талаарх мэдээлэл өгөх. ХОТСЗ-ын хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын хариуцах хариуцлага болон үүргийг тодорхой ялгаж салгах нь чухал. Энэхүү хоёр байгууллага хэрхэн хамтран ажиллахыг тодорхойлж өгөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын орон нутгийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай үндэсний, эсвэл бүсийн түвшинд түншилж ажиллах;
- Байгууллагын бүтэц, зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулахад нь, орон нутагт бүртгүүлэх, банкны данс нээх болон өөр бусад хууль зүйн дэмжлэг авахад нь туслах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагаа байгуулсны дараа ч гэсэн байнга туслах, тухайлбал ХОТСЗ-ын хөтөлбөрөөс зохион байгуулж буй сургалтанд урих. Ингэснээр тэд сургалтанд хамрагдаж байгаа хүмүүст хөгжлийн бэрхшээлийн талаар ямар ойлголт өгч байгааг ажиглаж болно.

Ашигласан материалууд

- Эрх мэдэлжүүлэх ба ядуурлыг бууруулах: Эх ном, Вашингтон ДС, Дэлхийн банк, 2002, (<http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/TOPICS/EXTPOVERTY/EXTMPOOWERMENT/ntentMDK:20260036-menuPK:543261-pagePK:148956> хийсэн).
- Карл М. Эмэгтэйчүүд ба эрх мэдэлжүүлэх: оролцоо ба шийдвэр гаргах. Лондон/Шинэ Жерси, Зед Бүүкс ХХК, 1995 он
- Уяман өвчтэй хүмүүсийг нийгмийн болон эдийн засгийн сэргээн засалтанд хамруулах талаарх удирдамж, Лондон, Уяман өвчний эсрэг ниймэглэгүүдийн олон улсын холбоо (I L E P) , 1999 он , (www.ilep.org.uk/fileadmin/uploads/Documents/Technical_Guides/sereng.pdf, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- Дуу хоолой нь гардаггүй хүмүүст дуу хоолой өгөх нь: Өмгөөлөл (адвокаси) хийх талаарх сургалтын гарын авлага. Лондон, Эрүүл мэндийн холбоос, 2007 он, (www.healthlink.org.uk/PDFs/cfalearningpublication.pdf, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн).
- ХБИ-ийн эрхийн тухай Конвенци, Нью-Йорк, НҮБ, 2006 он,
- (www.un.org/disabilities/, 2010 оны 3-р сарын 3-р сарын 30нд хандалт хийсэн).
- Хөгжлийн бэрхшээлийн эрхийн гэрээний талаарх НҮБ-ын уулзалтан дээр хөгжлийн бэрхшээлтэй залуучууд хамруулахыг уриалав, Лондон, Хүүхдийн эрхийн мэдээллийн сүлжээ , 2006 он , www.crin.org/resources/infodetail.asp?ID=6973Z&flag='news', 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- Долдугаар уулзалтан дээрх хүүхдийн уриалга. Лондон, Хүүхдийн эрхийн мэдээллийн сүлжээ , 2006 он , (www.crin.org/resources/infodetail.asp?ID=6973Z&flag='news', 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)

- Хөгжлийн бэрхшээлийн эрхийн талаарх НҮБ-ын гэрээн дээр хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын оролцоотойгоор гарын үсэг зурав. Нью-Йорк, НҮБ-ын Хүүхдийн Сан (ЮНИСЕФ), (он саргүй) (www.unicef.org/voyn/exlore/rights/exlore_3742.html, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- Та үүнийг мэдэх үү: ХБИ-ийн эрхийн тухай Конвенци, Нью-Йорк, НҮБ-ын Хүүхдийн Сан (ЮНИСЕФ), (он саргүй) (www.unicef.org/voyn/exlore/rights/exlore_3742.html, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- 10. Харилцацаа: харилцааны бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах хүмүүст зориулсан гарын авлага. Женев. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, 1997 он, (www.who.int/disabilities/publications/care/en/index.html, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- 11. Хамт олонд түшиглэсэн санаачлагуудад зориулсан сургалтын гарын авлага: Сургагч багш болон сургалтын оролцогч нарт зориулсан практик аргууд. Каиро, ДЭМБ-ын Газар дундын зүүн бүсийн оффис, 2006 он, 6 (www.emro.who.int/cbi/pdf/cbi_training_manual.pdf, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- 12. Хеландер, Е. Гай гамшиг ба эрхэм зэрэг: хамт олонд түшиглэсэн сэргээн засах хандлагын танилцуулга. Нью-Йорк, НҮБ-ын Хүний хөгжлийн хөтөлбөр, 1993 он, (www.einarhelander.com/PD-overview.pdf, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- 13. НҮБ-ын цагаачлагчдын дээд комиссар дахь хамт олонд түшиглэсэн хандлага. Женев, НҮБ-ын цагаачлагчдын дээд комиссарын газар, 2008 он, (www.unhcr.org/47ed0e212.html, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- 14. Сонгуулийн тогтолцооны олон улсын сангийн хөгжлийн бэрхшээлийн талаарх Финляндын төсөл. Вашингтон ДС, Сонгуулийн тогтолцооны олон улсын сан, 2009 он, (www.electionaccess.org/publications/news/02_01_04_Finland_Release.htm, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- 15. Томас М, Томас МЖ, Хамт олонд түшиглэсэн сэргээн засалтыг төлөвлөгч нарт зориулсан гарын авлага. Бангалор, Ази Номхон Далайн хөгжлийн бэрхшээлийн сэргээн засалтын сэтгүүл, 2003 он, (www.aifo.it/english/resouces/online/apdrj/Manual)
- 16. Даз М. Карнатакагийн хүний хөгжлийн тайлан 2005: хүний хөгжилд хөрөнгө оруулалт хийх нь. 2006 он, (<http://planning.kar.nic.in/khdr2005/Enlish/Main%20Report/Prelims.pdf>, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- 17. Өөрөө өөртөө туслах бүлгийг эхлүүлэх нь. Торонто, өөрөө өөртөө туслах хөгжлийн төв, 2009 он, (www.selfhelp.on.ca/start.html, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- 18. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх Үйл ажиллагааны дэлхийн хөтөлбөр, 1982 он, (www.un.org/disabilities/default.asp?id=23, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- 19. Эннс Х. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үүрэг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын холбооны баримт бичиг, Стокгольм, Бие дааж амьдрах төв, (он саргүй) (www.independentliving.org/docs5/RoleofOrgDisPeople.html, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)
- 20. Корнелье Х. Хамт олонд түшиглэн сэргээн засахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үүрэг, байр суурь: хуваагдсан шугамуудыг тэнцвэржүүлэх нь. Ази номхон далайн сэргээн засалтын сэтгүүл, 2009 он, 20 (1):3-14 (www.aifo.it/english/resouces/online/apdrj0109/dpo_cbr_corniele.pdf, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)

- 21. Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагыг тоймлон харах олон улсын зөвлөгөөн. Женев. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, 2003 он, (www.aifo.it/english/resouces/online/books/cbr/reviewofcbr/Report.Helsinki.CBR.May.pdf, 2010 оны 6-р сарын 10нд хандалт хийсэн)

ХОТС3 ХАНДЛАГЫН МАТРИЦ

